

Зөвшөөрч, хэрэгжүүлэх үүрэг хүлээсэн:
“Эхлэл Ургац Энержи” ХХК-ийн захирал



/Ю. Төмөрхүү/

ДУНДГОВЬ АЙМГИЙН ДЭЛГЭРХАНГАЙ
СУМЫН НУТАГТ ОРШИХ УРД ТАРАГТ
ГӨЛТГӨНИЙ ОРДЫГ ИЛ АРГААР АШИГЛАХ
ТӨСЛИЙН 2023 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ
МЕНЕЖМЕНТИЙН БИЕЛЭЛТИЙН ТАЙЛАН

/АШИГТ МАЛТМАЛЫН ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙН ДУГААР: MV-21268/
/ААН-ИЙН РЕГИСТРИЙН ДУГААР: 5353564/

Хянасан:

БОАЖЯ-ны ХБОБНУГ-ын мэргэжилтэн

/ /

Тайлан гаргасан:

Байгаль орчны мэргэжилтэн

/С. Сувд-Эрдэнэ/

Улаанбаатар хот
2023 он

ГАРЧИГ

1. ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ.....	2
2. ТӨСӨЛ ХЭРЭГЖИЖ БУЙ НУТГИЙН БАЙГАЛЬ ОРЧИН, НИЙГЭМ-ЭДИЙН ЗАСГИЙН ТӨЛӨВ БАЙДАЛ.....	3
2.5.1. Төслийн хүчин чадал.....	4
2.5.2. Ашигт малтмал.....	4
2.5.3. Ордын нөөц.....	5
3. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТИЙН ТАЙЛАН.....	6
4. СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТАЙЛАН.....	9
5. НӨХӨН СЭРГЭЭЛТИЙН ТАЙЛАН	14
Техникийн нөхөн сэргээлт	14
Биологийн нөхөн сэргээлт.....	15
6. ДҮЙЦҮҮЛЭН ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТАЙЛАН.....	19
7. НҮҮЛГЭН ШИЛЖҮҮЛЭХ, НӨХӨН ОЛГОВОР ОЛГОХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТАЙЛАН	24
.....	42
8. ТҮҮХ, СОЁЛЫН ӨВИЙГ ХАМГААЛАХ АРГА.....	25
ХЭМЖЭЭНИЙ ТАЙЛАН	25
9. ХИМИЙН БОДИСЫН ЭРСДЭЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТАЙЛАН	25
10. ОСОЛ, ЭРСДЭЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТИЙН ТАЙЛАН.....	26
11. ХОГ ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙН ТАЙЛАН	33
12. ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨР.....	39
13. УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТАЙЛАН	40
14. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ХУВААРЬ.....	43
15. АШИГЛАСАН МАТЕРИАЛ	47

1. ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ

Төслийн нэр:	Урд тарагтын гөлтгөнийн ордыг ил аргаар ашиглах төсөл
Төслийн хүчин чадал:	Жилд 40.0 мянган тонн гөлтгөнө олборлох хүчин чадалтай
Байршил:	Дундговь аймгийн Дэлгэрхангай сум
Хаяг:	Улаанбаатар хот Баянзүрх дүүрэг, 5-р хороо, 15-р хороолол, 202-29
Хариуцах хүн:	Байгаль орчны мэргэжилтэн С. Сувд-Эрдэнэ. Утас: 99700418
ААН-ийн нэр, батлуулсан огноо:	Тус төслийн БОННУ-г Байгаль орчны судалгаа, үнэлгээний “И ЭЧ ЭС ЭМ ХХК хийж гүйцэтгэсэн. 2019 он

Хүснэгт 1. Уулын ажлын тайлан

УРД ТАРАГТЫН ГӨЛТГӨНИЙ ОРДЫН 2023 ОНЫ УУЛЫН АЖЛЫН ТАЙЛАН		
	Түүхий эд	Нийт
Уурхайгаас олборлох түүхий эд	Нийт гөлтгөнө, Эзлэхүүн /мян.м ³ /	118.846
	Хөрс / мян.м ³ /	180.088
	Техникийн нөхөн сэргээлт Талбай /га/ Эзлэхүүн /мян.м ³ /	0.5 290.0
	Шимт хөрс Талбай /га/ Эзлэхүүн /мян.м ³ /	1.5 4.0
	Нийт уулын цул /мян. м³/	298.931

2023 оны 10 сарын эцсийн байдлаар

2. ТӨСӨЛ ХЭРЭГЖИЖ БУЙ НУТГИЙН БАЙГАЛЬ ОРЧИН, НИЙГЭМ-ЭДИЙН ЗАСГИЙН ТӨЛӨВ БАЙДАЛ

Төслийн нэр

Урд тарагтын гөлтгөнийн ордыг ил аргаар ашиглах

2.1. Төслийн зорилго

Төсөл хэрэгжүүлэгч "Эхлэл Ургац Энержи" ХХК нь Дундговь аймгийн Дэлгэрхангай сумын нутагт орших Урд тарагтын гөлтгөнийн ордыг Монгол Улсын хууль, дүрэм журмын хүрээнд эдийн засгийн хувьд үр ашигтай, байгаль орчинд ээлтэйгээр уурхайлалтын үйл ажиллагаа явуулж улмаар улс, орон нутгийн эдийн засгийн өсөлтөд бодитой хувь нэмэр оруулах, хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны дүрэм журмыг нэвтрүүлэх, орон нутгийн ард иргэдийг ажлын байраар хангах, уурхайн хаалт, нөхөн сэргээлтийг бүрэн хийх, орон нутагт хүлээлгэн өгөх зэрэгт энэхүү төслийн зорилго оршино.

2.2. Төсөл хэрэгжүүлэгч

Эхлэл Ургац Энержи ХХК
Улсын бүртгэлийн дугаар: 9011222037
РД: 5353564


2.3. Төсөл хэрэгжүүлэгчийн хаяг

Хаяг: Улаанбаатар хот Баянзүрх дүүрэг, 5-р хороо, 15-р хороолол, 202-29
Утас: 99109100, 91919100

2.4. Төслийн байршил

Урд тарагтын гөлтгөнийн орд нь Дундговь аймгийн Дэлгэрхангай сумын нутагт орших бөгөөд Улаанбаатар хотоос баруун урд зүгт 450 км, Дэлгэрхангай сумын төвөөс баруун урагш 34 км-т тус тус байрлана. Дэд бүтцийн хувьд сул хөгжсөн ба Улаанбаатар - Өмнөговь чиглэлийн хатуу хучилттай авто замаас 120 км зайтай.

Урд тарагтын ордын MV-021268 тоот ашиглалтын тусгай зөвшөөрлийг АМГТГ-ын кадастрын хэлтсийн даргын 2018 оны 12-р сарын 26-ны өдрийн 904 тоот шийдвэрээр 2019 оны 01-р сарын 11-ээс 2049 оны 01-р сарын 11-ний өдрийг хүртэл буюу 30 жилийн хугацаатайгаар "Эхлэл Ургац Энержи" ХХК-д олгосон байна. Уг зөвшөөрлийн талбай нь Дэлгэрхангай уул нэртэй газар 221.94 га талбайг хамарна.



Зураг 1. Төслийн байршил

Хүснэгт 2. Тусгай зөвшөөрөл бүхий талбайн өнцгүүдийн газар зүйн солбицлууд

№	Талбай	Уртраг	Өргөрөг
1	221.94 га	104° 28' 46.1"	45° 1' 51.5"
2		104° 33' 33"	45° 1' 51.5"
3		104° 33' 33"	44° 59' 1.52"
4		104° 28' 46.1"	44° 59' 1.52"

2. 5. 1 .

Ордын хувьд 40 мян.тн цэвэр гөлтгөнө олборлох хүчин чадалтай ба ашиглалтын хугацаанд нийт 400.0 мян.тн гөлтгөнө олборлож, 620.9 мян.м³ хөрс хуулна.

Одын хэмжээнд цэвэр гөлтгөнийн нөөц нь /В+С/ зэргээр 858,361.42 тн, үүнээс бодитой /В/ зэрэглэлийн нөөц нь 771,391.08 тн, боломжтой /С/ нөөц нь 86,970.34 тн тус тус хамаарна.

Олборлосон цэвэр гөлтгөнийг өөрсдийн гадаад тээврийн шланзаар Хулд сум хүртэл 120 км зайд тээвэрлэн хүргэнэ. Хулд суманд гэрээт компанийн ачааны машинд SEM 660D маркийн дугуйт ачигчаар дахин ачилт хийж цементийн үйлдвэрүүдэд нийлүүлэхээр төлөвлөж байна.

2.5.2. Ашигт малтмал

Урд тарагт ордын орчимд Монгол орны гөлтгөнийн голлох нөөц бүхий Тарагт, Ширээ уул, Ширээгийн хөндий зэрэг гөлтгөнийн бүлэг ордууд, олон тооны илрэл байдаг.

Дээрх ордуудад “Талст гөлтгөнө”, “Тээлийн шонхор”, “Эрдэнэгипс”, “МакЦемент” зэрэг компаниуд ашиглалтын тусгай зөвшөөрлийг эзэмшин, олборлолтын ажиллагаа явуулж байна. Төвлөрсөн төлөвлөгөөт эдийн засгийн үед Тарагтын ордыг ашиглаж, Хөтөлийн цемент шохойн үйлдвэрийн гөлтгөнийн хэрэгцээг хангаж байсан бөгөөд сүүлийн үед Ширээ уулын

ордын хэсэгт “Түмэн-анд” ХХК, “Талст гөлтгөнө” ХХКомпаниуд ашиглалтын үйл ажиллагаа явуулж байна. Ордын дүүрэгт мэдэгдэж байгаа хайгуулын ажил хийгдээгүй илрэлүүдээс Бор хошууны илрэл хамгийн хэтийн төлөв өндөр, нөөц ихтэй илрэл бөгөөд Дэлгэрхангай уулын өврийн энэхүү томоохон хөндийд цаашид ч гөлтгөнийн томоохон орд илрэлүүдийг шинээр нээн илрүүлэх бүрэн боломж бий.

Урд тарагт орд орчмын гөлтгөнийн орд, илрэлүүд нь гарал үүслийн хувьд дүүргийн палеогеографийн болон цаг уурын нөхцөлтэй нягт уялдаатай юм. Дээд палеоген буюу олигоцены /ЕЗ/ үед дүүрэг нь ихээхэн чийглэг уур амьсгалтай байсан бөгөөд нуурын сав газар өргөсөн тэлж, гидрогеографийн сүлжээ харьцангуй шигүү байсан байна. Палеогены төгсгөл үе хүртэл эх газрын хурдас нь гидрографийн сүлжээ болон нуурын сав газрын өөрчлөлтөд нөлөөлсөн цаг уурын тогтворгүй нөхцөл бүрэлдэн бий болжээ. Энэ үеэс хуурай уур амьсгал зонхилон, хурдас хуримтлал тогтворгүй болж, энэ нь өнөө үед чулуулгийн фацийн тод өөрчлөлтөөр илэрдэг.

Урд тарагт гөлтгөнийн орд нь давхарга хэлбэрийн тогтоцтой тунамал ордын төрөлд хамаардаг. Тэрээр цэвэр нуурын гаралтай бөгөөд багавтар хэмжээний давстай устай нуур цөл, хагас цөлийн нөхцөлд хатаж уурших үед хүхэр хүчилт кальцийн тунадас бууж бүрэлджээ. Хүхэр хүчлийн кальци нь усан санд анх бүрэлдэхдээ давс түүнд хуримтлагдаж эхлэх үеэс эхэлсэн бөгөөд хүхэр хүчлийн кальциас өөр давсны төрөл түүнд тогтоогдоогүй байна. Энэ нь уусмал дахь түүний агууламж зайлшгүй багасах хүртэл хэмжээнд хүрээгүй байгаагаар тайлбарлагддаг. Газрын гадарга дээрх хөрсний ус нь хуурай уур амьсгалын нөлөөгөөр түргэн хатахад, түүн дэх хүхэр хүчлийн кальцийн агууламж нэмэгдэн ханасан уусмал бий болдог. Үүний дараа агуулагч чулуулагт кальцийн сульфатын жижиг бичил талстууд бүрэлддэг бөгөөд энэ нь өнөө үед гөлтгөнийн давхарга үүсжээ.

Хүхэр хүчлийн кальцийн өндөр агууламж бүхий усан уусмалын циркуляцын үр дүнд гөлтгөнөжсөн шавар болон элсэн чулууны ан цаваар нэвчилтийн гөлтгөнө буюу гөлтгөнийн нимгэн судлууд, өөрөөр хэлбэл үелэг тогтоцтой селенитүүд үүсжээ.

Мөн доод цэрдийн тэвшний говь формац, дээд цэрдийн сайншанд формац, олигоцений ангилагдаагүй хурдаснуудын улаан өнгийн шавар нь барилгын материалын тоосгоны шавар, тэвшийн говь формацын хурдастай холбоотойгоор хүрэн нүүрс шинээр илрэх боломжтой бөгөөд тэр чиглэлээр эрэл, хайгуулын ажлыг цаашид анхаарах хэрэгтэй.

Тарагтын гөлтгөнийн орд болон түүний дүүрэг дэх эрэл-зураглал, хайгуулын ажлын үр дүнгийн тайланд К.П.Атабекьянц нар 1961 онд хайгуулын талбайн зүүн урд хэсэг “Участок-V” дугаартай сидеритын эрлийн хэсгийг ялгасан байдаг.

Тус сидеритын илрэл нь 2014 оны “УГЗ-200 Өмнөд Монгол-VI” 1:200 000 масштабтай геологийн иж бүрдэл зураг зохиох ажлаар Б.Нямаа, А.Амаржаргал нарын гүйцэтгэсэн буюу хамгийн сүүлийн үеийн геологийн судалгааны ажлаар тэмдэглэгдээгүй, бидний хайгуулын ажлаар илрэл нь өнөөгийн түвшинд тогтоогдоогүй юм. Хайгуулын талбай орчимд сидеритын илрэл цаашид тогтоогдох бүрэн боломжтой юм.

2.5.3. Ордын нөөц

Гөлтгөнөжсөн давхарга нь бараг хэвтээ, зүүн урагш 1-2° өнцгөөр аажим уналттай, тархалтын хувьд зүүн хойноос баруун урагш сунасан, дунджаар 400 х 700 м хэмжээтэй, зуувандуу давхарга хэлбэрийн биет үүсгэдэг. Ашигт давхаргын нийт зузаан 1.2-6.1 м, дунджаар 3.14 м, хучаасны дундаж зузаан 1.43 м байна.

3. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТИЙН ТАЙЛАН

Иргэн, аж ахуйн нэгж байгууллагын тухайн жилд хэрэгжүүлэх “Байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулах, хянан батлах, тайлагнах журам”-ыг Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2019 оны 10 дугаар сарын 29 –ний өдрийн А/618 тоот тушаалаар шинэчлэн баталсан болно.

Төсөл хэрэгжүүлэгч иргэн, хуулийн этгээдийн байгаль орчныг хамгаалах талаар хүлээсэн үүргээ биелүүлэх, тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг боловсруулах, түүнийг хянан батлах, хэрэгжилтийг тайлагнахтай холбогдсон харилцааг зохицуулахад энэхүү журмын зорилго оршино. Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөө гэж Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуулийн 9.8-д заасан төлөвлөгөөг ойлгоно. Ерөнхий үнэлгээ хийсэн байгууллагын хянаж баталсан тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөө нь төслийн үйл ажиллагааг эхлүүлэх, үргэлжлүүлэхийг зөвшөөрсөн байгаль орчны үндсэн баримт бичиг болно.

Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг төсөл хэрэгжүүлэгч иргэн, хуулийн этгээд боловсруулж, ерөнхий үнэлгээг хийсэн байгаль орчны асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллага болон аймаг, нийслэлийн байгаль орчны алба хянаж, батална.

Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний байгаль хамгаалах төлөвлөгөөнд байгалийн нөөц баялгийг ашиглах явцад байгаль орчныг доройтохоос урьдчилан сэргийлэх, сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах, үлдэгдэл нөлөөллийг дүйцүүлэн хамгаалах, нөхөн сэргээх, нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох, түүх соёлын өвийг хамгаалахтай холбогдсон арга хэмжээг тодорхойлон, шаардагдах хөрөнгө зардлыг тооцож, хариуцах этгээд, хэрэгжүүлэх хугацаа, баримтлах хууль, журам, аргачлал, стандартыг тодорхойлж тусгасан байна.

Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний орчны хяналт шинжилгээний хөтөлбөрт байгаль орчны төлөв байдлын өөрчлөлт, сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, арилгах, бууруулах арга хэмжээ үр дүнтэй байгаа эсэх, сөрөг нөлөөллийн эрчим, цар хэмжээ нь зөвшөөрөгдөх хэмжээнд байгаа эсэхийг тогтоох ажиглалт, хэмжилт, дээжлэлт хийх байршил, давтамж, хариуцах этгээд, шинжилгээний арга, шаардагдах зардлыг тооцож тусгана.

Төсөл хэрэгжүүлэгч иргэн, хуулийн этгээд тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг байгаль хамгаалах хууль тогтоомж, байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний үр дүн, батлагдсан байгаль орчны менежментийн төлөвлөгөө (5 жил)-нд үндэслэн, Байгаль орчны нөлөөллийн үнэлгээний аргачлалын 4 дүгээр хэсгийг баримтлан жил бүр шинэчлэн боловсруулна.

Тухайн төслийн байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний судалгааны үр дүнг үндэслэн боловсруулж батлуулсан байгаль орчны менежментийн төлөвлөгөө нь 5 жилээс дээшгүй хугацаатай байх бөгөөд уг төлөвлөгөөнд нөлөөллийн нарийвчилсан үнэлгээ батлагдах жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг нарийвчилсан үнэлгээ хийх эрх бүхий байгууллага, төсөл хэрэгжүүлэгч хамтран боловсруулж батлуулж болно.

Төсөл хэрэгжүүлэгч байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээ батлагдсанаас хойших ашиглалтын жил бүр байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хариуцан боловсруулж, Байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад

хүргүүлнэ.

Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд төсөл хэрэгжүүлэгчийн талаарх мэдээлэл, төслийн хэрэгжилтийн явц, ашиглаж байгаа техник технологи, төсөл хэрэгжиж байгаа орчин, байгаль орчны төлөв байдал, төслийн гол ба болзошгүй сөрөг нөлөөлөл, түүнийг бууруулах арга хэмжээний талаарх товч тодорхойлолт, баримтлах хууль тогтоомж, стандартын шаардлага болон авч хэрэгжүүлэх арга хэмжээний зардлыг тодорхой тусгана.

Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний орчны хяналт-шинжилгээний хөтөлбөрт төсөл хэрэгжүүлэх явцад байгаль орчинд үүсч болзошгүй өөрчлөлтийг хянах, шинжлэх объект, байршил, баримтлах стандарт, арга аргачлал, хугацаа, хариуцах этгээд, хяналт шинжилгээний үр дүнг тайлагнах талаар тодорхой тусгана.

Төсөл хэрэгжүүлэгчээс тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийн тайланг хүлээж авсан аймаг, нийслэлийн Байгаль орчны газар түүний биелэлтийг шалгаж, дүгнэлт гаргах ажлын хэсгийг аймаг, нийслэлийн Засаг даргын захирамжаар байгуулж, ажиллуулан дүгнэлтийг 12 дугаар сарын 1-ний дотор гаргуулах ба уг ажлын хэсэгт аймаг нийслэлийн Засаг даргын тамгын газрын хөгжлийн бодлогын хэлтэс, байгаль орчны газар, мэргэжлийн хяналтын газар, сав газрын захиргаа, сум, дүүргийн Засаг даргын тамгын газрын төлөөлөл, байгаль орчны хяналтын улсын байцаагч, байгаль хамгаалагч, газрын даамал орно.

Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийн тайлан, түүнд хийсэн ажлын хэсгийн дүгнэлтийг үндэслэн, биелэлтийг хянаж, дараагийн жилд хэрэгжүүлэх байгаль орчны менежментийн төлөвлөгөөг батална.

Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг ерөнхий үнэлгээ хийсэн байгууллагын асуудал хариуцсан нэгж хүлээн авч хянан, эрх бүхий албан тушаалтан баталгаажуулна.

Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний бүрэлдэхүүн хэсгийн биелэлтийг энэхүү журмын 3 хавсралтад заасны дагуу хувиар тооцож, үнэлэх ба хэсгүүдийн жигнэсэн дундаж хувь нь 90-ээс дээш байвал батална.

2023 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийг тайланг хэрэгжүүлэхэд нийт зардал Гучин гурван сая хоёр зуун жаран долоон мянга (**33'267'000**) төгрөг зарцуулсан байна.

Хүснэгт 3. Байгаль орчны менежментийн тайлангийн нийт зардал

№	Байгаль орчны менежментийн тайлангийн задаргаа	Төсөв /мян.төг/	Тайлбар
1	Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний тайлан	14880.0	
2	Нөхөн сэргээлтийн тайлан	9880.0	
3	Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний зардал	3500.0	
4	Нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох арга хэмжээний тайлан	-	Нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох арга хэмжээ авагдахгүй.
5	Түүх, соёлын өвийг хамгаалах арга хэмжээний тайлан	-	Түүх соёлын өвийг хамгаалах арга хэмжээ авагдахгүй.
6	Болзошгүй аюул, ослын нөлөөллийн зардал	300.0	
7	Хог, хаягдлын менежментийн арга хэмжээний зардал	460.0	
8	Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр	1427.0	
9	Удирдлага зохион байгуулалтын тайлан	2500.0	
10	Олон нийтэд тайлагнах хуваарь, тайлан	500.0	
Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийн тайлангийн зардал		33 267.0	

4. СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТАЙЛАН

Уурхайн үйл ажиллагаанаас байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөлөл болон болзошгүй сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээ, түүнээс урьдчилан сэргийлэх, үр дагаврыг арилгах талаар авч хэрэгжүүлж буй үйл ажиллагаа, тэдгээрийг хэрэгжүүлсэн хугацаа, зардал зэргийг оруулсан болно.

Хүснэгт 4. Байгаль орчны сөрөг нөлөөллийг бууруулах ажлын тайлан

Гол болон болзошгүй сөрөг нөлөөлөл	Бууруулах арга хэмжээ	Цар хүрээ	Нэгжийн өртөг /мян. төг/	Гүйцэтгэл	Зураг
Ургамал болон хөрсөн бүрхэвч					
Төслийн үйл ажиллагаа эхэлснээр ургамлан нөмрөг антропоген нөлөөлөлд өртөх	Төслийн талбайн орчмын ургамлан нөмрөгийг хамгаалах чиглэлээр сургалт зохион байгуулах, ажилчдад мэдээлэл өгөх	Төслийн хүрээнд	Удирдлага зохион байгуулалтын зардалд тусгагдсан.	Улаанбаатар хотод байрлах төв оффист сургалтыг зохион байгуулсан	
Уурхайн ахуйн үйл ажиллагаанаас хөрс бохирдох	Уурхайн ахуйн үйл ажиллагаанаас хөрс бохирдохоос урьдчилан сэргийлэх бохирдсон тохиолдолд арилгах арга хэмжээ авч хэрэгжүүлэх	Төслийн хүрээнд	Хашааны нэгж үнэ 98.0*150 ширхэг хашаа = Нийт үнэ 14700.0	Уурхайн аюулгүй ажиллагаа болон байгаль орчинд нөлөөлөх сөрөг нөлөөллийг бууруулах зорилгоор ангийн замуудыг даланжуулж давхардсан эсвэл дахин шинэ зам гарахаас урьдчилан сэргийлэн хашаажуулсан.	

<p>Тээврийн хэрэгслийн хөдөлгөөнөөр хөрс талхлагдах</p>	<p>Авто тээврийн хэрэгслийн сул хөдөлгөөнийг хязгаарлах, тогтсон маршрутын дагуу явах, технологийн замыг тэмдэгжүүлэх, өмнө байршуулсан тэмдэг тэмдэглэгээг шинэчлэн засаж сайжруулах</p>	<p>Төслийн хүрээнд</p>	<p>Нэг тэмдгийн үнэ - 30.0 төг 6 ш *30.0=180.0</p>	<p>Уурхайн технологийн зам дагуу шинээр замын тэмдэг 6 ширхэгийг байршуулсан.</p>	
Агаарын чанар					
<p>Техник хэрэгслийн хөдөлгөөн ажлын үр дүнд агаар орчны тоосжилт үүсэж орчны бохирдол үүсгэх</p>	<p>Машин механизмуудын хөдөлгөөнөөр тоосжилт үүсэхээс сэргийлж технологийн зам дагуу хурдны тэмдэглэгээ байрлуулах өмнө ашиглаж байсан тэмдэг тэмдэглэгээг солих засаж сайжруулах</p>	<p>Технологийн зам дагуу</p>	<p>Үйл ажиллагааны зардалд тусгасан</p>	<p>Машин механизмуудын хөдөлгөөнөөр тоосжилт үүсэхээс сэргийлж технологийн зам дагуу хурдны тэмдэглэгээ байрлуулах өмнө ашиглаж байсан 4 ширхэг тэмдэг тэмдэглэгээг засаж сайжруулж тавьсан.</p>	
Амьтан					
<p>Дуу чимээ, техник хэрэгслийн хөдөлгөөн зэргээс үүдэн амьтад дайчих, тоо толгой багасах</p>	<p>Өвлийн хар зудтай жилүүдэд орон нутгийн байгаль орчны байгууллагатай хамтран ан амьтдад өвс, хужир тавьж өгөх гэх мэт ажилд хамтран ажиллах</p>	<p>Орон нутгийн хэмжээнд</p>	<p>Үйл ажиллагааны зардалд тусгасан</p>	<p>Үйл ажиллагаанаас ан амьтдад, сөрөг нөлөө үзүүлэхээс сэргийлж уурхайн дарга байнгын хяналт тавин ажилладаг.</p>	
Сөрөг нөлөөллийг бууруулах ажлын зардал			148800.0₮		

Байгаль орчны сөрөг нөлөөллийг бууруулах ажлын зардалд 14'880'000 төгрөг зарцуулсан байна.

СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ ЧИГЛЭЛЭЭР АВЧ ХЭРЭГЖҮҮЛСЭН АЖИЛ

Замын тэмдэг тэмдэглэгээ

Тарагт уурхайн агаар, хөрс, ургамалд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах зорилгоор замын тэмдэг тэмдэглэгээг байрлуулбал зохих 4 газарт байрлуулсан.



Зураг 2. Замын тэмдэг тэмдэглэгээ



Зураг 3. Урд тарагт уурхайн кемпийн хашаажуулалт хийсэн байдал

Олон салаа зам гаргаж хөрсний эвдрэл, ургамлын талхагдал болохоос сэргийлж технологийн зам дагуу далан босгож хамгаалах арга хэмжээ авч хэрэгжүүлсэн. Мөн шаардлагатай газаруудад тэмдэг тэмдэглэгээ байрлуулсан.



Зураг 4. Технологийн зам дагуу



Зураг 5. Замын тэмдэг тэмдэглэгээ



Зураг 6. Ан амьтдад өвс, хужир тавьж өгөх

5. НӨХӨН СЭРГЭЭЛТИЙН ТАЙЛАН

2023 онд олборлолтын үйл ажиллагаа 0.4 га талбайд хийгдсэн.

2023 онд олборлолтын үйл ажиллагаа шинээр ахилт хийгдэхгүй өмнөх оны шимт хөрс хуулсан талбайд олборлолт хийгдсэн.

Үржил шимт өнгөн хөрсийг хуулах, тээвэрлэх ажил: Тус уурхайн эдэлбэр газар орчмоос хуулах үржил шимт өнгөн хөрсний дундаж зузаан 0.3 м байна. Шимт хөрсийг дугуйт ачигчаар хуулж овоолго үүсгэн хураана. Энэхүү түр овоолгын өндөр 2-5м-ээс ихгүй, сул чөлөөтэй, ямар ч нягтаршуулалгүй, овоолгын гадаргуу дээгүүр автосамосвал, дугуйт ачигч гэх мэт хүнд даацын тоног төхөөрөмж явахгүй байх шаардлагыг баримтална. Энэ ажлыг уурхайн инженер техникийн, ялангуяа технологи, маркшейдер инженерүүд жил бүрийн уулын ажлын төлөвлөгөөг зохиохдоо нарийвчлан тусгаж өгнө.

Уурхайн хаалтын үед нөхөн сэргээлтийн ажлыг малын бэлчээрийн чиглэлээр нөхөн сэргээлтийн ажлыг хийж гүйцэтгэх бөгөөд 2023 онд 0.5 га талбайд 29000 м³ эзлэхүүнтэй техникийн нөхөн сэргээлт хийж гүйцэтгэнэ. Энэхүү техникийн нөхөн сэргээлт хийсэн талбайд дараагийн жилүүдэд биологийн нөхөн сэргээлт хийн ургамалжуулах байгалийн төрхөд нь оруулах ажлууд хийгдэхээр төлөвлөж байна. Эвдэрсэн газрыг нөхөн сэргээх үйл ажиллагаа нь 3 үндсэн үе шатаар хийгдэнэ.

1. Уул-техникийн нөхөн сэргээлт /овоолгыг хэвгийжүүлэх, хэлбэржүүлэх, шимт хөрсөөр бүрэх зэрэг ажлууд/
2. Биологийн нөхөн сэргээлт /Уул техникийн нөхөн сэргээлт хийгдэж дууссан газрыг ургамалжуулж ажлыг эхлүүлэх, хөрсийг бордох, сайжруулах, арчлах, тордох талаар тусгагдсан ажлууд хийгдэнэ./
3. Техникийн болон биологийн нөхөн сэргээлтийн дараах мониторинг хийсэн.

Урд тарагтын гөлтгөнийн ордыг ашиглаж дууссаны дараа ил уурхайн дээд мөргөцгөөс 5 метрийн зайд 2.5 метрээс багагүй өндөртэй хашлага барьж, мөн хүн, авто тээврийн хэрэгсэл зайлшгүй явах замын ойролцоо хэсэгт анхааруулах тэмдэг хадсан байна. Түүнчлэн хөрсний овоолгын хажуугийн налуууг 18 градус хүртэл хэвгийжүүлж хүн болон мал, амьтан явахад хүндрэлгүй болгоно. Хөрсний овоолго, гадаад болон дотоод тээврийн зам, ажилчдын хотхонд шимт хөрсийг 0.3 метрийн зузаантай тараан байрлуулж биологийн нөхөн сэргээлтийн ажилд бэлтгэнэ. Эвдэрсэн газрыг нөхөн сэргээх техникийн үе шатанд дараах үндсэн ажлыг гүйцэтгэнэ. Үүнд:

- ◁ Уул уурхайн үйл ажиллагаанд өртөж, нөхөн сэргээхээр төлөвлөж буй талбайг овор хэмжээ ихтэй чулуулаг, хог хаягдал, үйлдвэрлэлийн зориулалтаар ашигласан байгууламжуудаас чөлөөлж, гарсан хог хаягдлыг зөвшөөрөгдсөн газарт зайлуулах
- ◁ Талбайд үүссэн овор товон гадаргууг сийрүүлэн тэгшлэх, налуу гадаргууг орчных нь гадаргуугийн хэлбэр төрхтэй ойртуулан хэлбэршүүлэх, тогтворжуулах, оройг нь намсгах



- ◁ Ус татах болон ус зайлуулах шугам хоолой байрлуулсан газар, далан, суваг шуудууг булж тэгшлэх, дэнжилсэн хана мөргөцгийг налуулах, эцэст нь нарийвчилсан тэгшилгээ, хэлбэршүүлэлт хийх
- ◁ Нөхөн сэргээлт хийж буй гадаргууг эхлээд шимлэг хурдсаар, дараа нь ургамлын үндэс бүхий давхарга үүсгэх зорилгоор шимт хөрсөөр хучих
- ◁ Уурхайн зориулалтаар хийсэн шороон хаалт, далан, овоолгыг хэвгийжүүлэх, хэлбэршүүлэх замаар нөхөн сэргээх
- ◁ Шаардлагатай тохиолдолд биологийн нөхөн сэргээлтэд тохирохгүй хөрс чулуулгийг эхлээд халхавч давхаргаар, дараа нь шимт хөрсөөр хучих

Нөхөн сэргээлтийн үйл ажиллагааны техникийн үе шат бүрэн дуусаж, овоолгын болон талбайн хөрс чулуулаг тогтворжиж, нягтарсны дараа овоолгод хадгалж байсан шимт хөрсийг эргүүлэн байршуулах замаар эвдэрсэн газрын биологийн нөхөн сэргээлтийн ажлыг эхлүүлнэ. Нөхөн сэргээлтийн биологийн үе шатанд гүйцэтгэх үйл ажиллагааны үндсэн чиглэл нь малын бэлчээрийн чиглэл байх бөгөөд тухайн бүс нутгийн онцлогт тохирсон ургамлын төрөл зүйлийг тарьж ургуулж арчлах замаар үйлдвэрлэлийн үйл ажиллагааны үед элэгдэж, эвдэрсэн газрыг нөхөн сэргээж, хүрээлэн буй орчинд үзүүлэх сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх явдал юм.

Биологийн нөхөн сэргээлтийн ажлыг олборлолтын ажил эхлэхийн өмнө уурхайн эдэлбэрийн байгаль орчны суурь нөхцөл байдлыг тодорхойлох урьдчилсан судалгаа явуулах, дараа нь уг судалгааны үр дүн болон бусад мэдээ, мэдээлэлд үндэслэн ургамалжуулах ажлын чиглэлийг тогтоох, эцэст нь техникийн нөхөн сэргээлт хийсэн талбайд шимт хөрсний үе үүсгэн ургамалжуулалтыг байгалийн аясаар болон зохиомлоор тарьж ургуулах гэсэн дэс дараалалтайгаар гүйцэтгэнэ. Биологийн нөхөн сэргээлтийн үед сонгон авсан ургамлын төрөлд тохируулан хөрсийг сайжруулах, тухайн орон нутгийн нөхцөлд илүү зохицсон бутлаг ба модлог ургамлууд тарих нь илүү үр дүнтэй. Ургамалжуулалтад арчилгаа бага шаардах, зардал хямдтай олон наст ургамал болох ерхөг, согооврын үрийг суулгах нь түргэн нөхөн сэргээлтийг түргэсгэнэ. Хөрсний шинж чанар шаардлага хангахгүй тохиолдолд хөрс сайжруулалтын арга хэмжээг хэрэгжүүлнэ. Хэрэв хөрс хэт хүчиллэг юм уу шүлтлэг байвал саармагжуулах шаардлагатай.

Хөрсний нягт 2.2-2.7 г/см³ байвал зохистой бөгөөд нягт нь 3.0 г/см³-ээс дээш байвал хөрсийг сийрэгжүүлэх арга хэмжээ авна. Хөрсний шимт чанарыг нэмэгдүүлэх, ургамлын ургах нөхцөлийг хангахын тулд төрөл бүрийн бордоо хэрэглэдэг. Техникийн нөхөн сэргээлтийн дараа нөхөн сэргээж буй хөрсний агротехникийн шинж чанарт тохируулан мод, бут, ургамлыг нөхөн сэргээлтийн стандартын дагуу сонгож тариална. Техникийн ерөнхий шаардлага” MNS 5918:2008 стандартыг баримтална.

Хүснэгт 5. Нөхөн сэргээлтийн ажлын зардлын тооцоо

Нөхөн сэргээлтийн зорилт	Төлөвлөлт	Гүйцэтгэл	Нийт зардал, /мян. төг/	Зураг
Техникийн нөхөн сэргээлт				
Лицензийн талбайд олборлолт явуулж эхлэхээс өмнөх байгалийн унаган төрхөнд ойртуулан хүн мал амьтанд аюулгүй ландшафт бий болгох	Уурхайн ашиглалтын явцад ашиглагдсан орон зайг дотоод овоолгоор дүүргэж явсан	2023 онд техникийн нөхөн сэргээлтийг Талбай – 0.5 га Эзэлхүүн – 290000 м ³	9000.0₮	
Уурхайн кемп	Тэрбум мод үндэсний хөдөлгөөний хүрээнд онд Уурхайн кемпийн тохижилтонд 30 ширхэг хайлаас модыг тарихаар төлөвлөж байна	Тэр бум мод үндэсний хөдөлгөөний хүрээнд онд Уурхайн кемпийн тохижилтонд 50 ширхэг хайлаас модыг тарьсан.	Нэг ширхэг хайлаас мод 4.0*50 ширхэг = Нийт 200.0₮	
Дэлгэрхангай сумын Тарагт худаг	Дэргэрхангай сумын ЗДТГ-тай хамтран мод тарих үйл ажиллагааг хамтран зохион байгуулж, 170 ширхэг хүлээлгэн өгөхөд бэлдсэн.	170 ширхэг хайлаас мод тарих	Нэг ширхэг хайлаас мод 4.0*170 ширхэг = Нийт 680.0₮	
Нийт			9880.0₮	

2023 ОНЫ ТЕХНИКИЙН НӨХӨН СЭРГЭЭЛТ



Зураг 7. Карьер байсан хэсгийг дарсан байдал



Зураг 8. Техникийн нөхөн сэргээлт хийсэн талбайн булангийн цэг



Зураг 9. Техникийн нөхөн сэргээлт дууссан байдал



Зураг 10. Уурхайн кемпийн тохижилтод мод суулгаж буй байдал

6. ДҮЙЦҮҮЛЭН ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТАЙЛАН

БОАЖЯ-наас төсөл хэрэгжүүлэгчийг Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээг хэрэгжүүлэхийг шаардсан тохиолдолд “Дүйцүүлэн хамгаалал хийх ажлын төлөвлөгөө”-г тусад нь тайлан болгон боловсруулж ажиллахыг санал болгож байна. Мөн жил бүр төсөл хэрэгжих орон нутгийн санал авч дүйцүүлэн хамгааллын талаар тохиролцон хамтран төлөвлөгөө гарган бүтээлчээр ажиллаж болох юм. Уурхай нь 10 жилийн дараагаар бүрэн хаагдаж, уурхайн ухшийг нөхөн дүүргэж, налууг хэвгийжүүлэн, биологийн нөхөн сэргээлт хийх тул уурхайн үйл ажиллагаанаас үүдэн нөхөн сэргээгдэх боломжгүй газар үлдэхгүй. Харин тоосжилтын тархалтын нөлөө, дуу чимээний бохирдол, газрын хэвлийн өөрчлөлт, эвдрэл зэргээс үүдсэн зарим амьтан ургамал устаж, дайжсан байх магадлалтай ба уурхай нь хэдийгээр нөхөн сэргээлт хийж, талбайг бүрэн ургамалжуулах ч байгалийн өөрийн аясаар бүрэлдсэн экосистемийг гүйцэхгүй. Иймд энэ хэмжээний хохирлыг тооцох боломжгүй байгаа тул дүйцүүлэн хамгаалах арга хэмжээг хэрэгжүүлнэ.


Иймд компанийн нийгмийн хариуцлага болон дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний хүрээнд орон нутгийн төр захиргааны байгууллагатай зөвшилцсөний үндсэнд дүйцүүлэн хамгаалах зарчимд нийцсэн газарт нөхөн сэргээлтийн ажлыг хийж, дүйцүүлэн хамгаалах арга хэмжээг авч хэрэгжүүлбэл зохино. Дүйцүүлэн хамгаалах ажилд шаардлагатай зардлыг тооцоолход нэг жилд 3 000 000 төгрөг болно.


Дүйцүүлэн хамгаалах ажлын хүрээнд ургамал тарималжуулахаас гадна тус тусгай зөвшөөрлийн орчим олборлолт явуулчаад нөхөн сэргээлт хийхгүйгээр хаяж явсан талбайнууд байдаг бөгөөд тухайн эвдэрсэн газруудад техникийн болон биологийн нөхөн сэргээлт хийх ажлыг санал болгож байна.

Мөн дүйцүүлэн хамгаалах ажлын хүрээнд БОАЖ, ШУА, Ургамлын аймаг ангилалзүйн лаборатори, ерөнхий болон сорилын биологийн хүрээлэн нарын 2018 онд гаргасан Монгол орны тарималжуулах шаардлагатай ургамлын төрөл зүйлүүд (зөвлөмж)-өөс дараах ургамлуудыг тарималжуулахыг зөвлөж байна. Үүнд: Өмхий шимэлдэг-*Dracoscephalum foetidum*, Зүүнгарын гоёо-*Synomorium songaricum*, Зэлэн зангуу-*Tribulus terrestris* гэх ургамлыг тарималжуулах ажлыг санал болгосон.

2023 онд Дүйцүүлэн хамгаалах ажлын хүрээнд Дундговь аймгийн Дэлгэрхангай сумын ЗДТГ-аас 2-р багийн иргэдийн хүсэлтийн дагуу 2-р багийн төвд байрлах гоожуурын худгийн иргэн тойронгийн засаж сайжируулан мал ундаалахад тохиромжтой болгох арга хэмжээг авч хэрэгжүүлэн ажилласан.

Хүснэгт 6. Дүйцүүлэн хамгаалах ажлын зардлын тооцоо

№	Дүйцүүлэн хамгаалах зорилт	Дүйцүүлэн хамгаалах хийгдсэн ажил	Арга хэмжээний цар хүрээ	Тоо хэмжээ	Нийт зардал, /мян.төг /	Тайлбар	Зураг
1	Дэлгэрхангай сумын Тарагт худгийн гоожуурыг сэргээн засварлах	2023 онд Дүйцүүлэн хамгаалах ажлын хүрээнд Дундговь аймгийн Дэлгэрхангай сумын ЗДТГ-аас 2-р багийн иргэдийн хүсэлтийн дагуу 2-р багийн төвд байрлах гоожуурын худгийн иргэн тойронгийн засаж сайжируулан мал ундаалахад тохиромжтой болгох арга хэмжээг авч хэрэгжүүлэн ажилласан.	Дэлгэрхангай сум	0.3 га талбай	3500.0₮	Тарагт худгийн гоожуурыг сэргээн засварлах цогц ажлын хүрээнд эхний ээлжинд 40 метр урттай 2 ширхэг онгоц байрлуулан мал, ан амьтан ус уухад тохиромжтой байдлаар шийдэж байна. Худаг орчмын цэвэрлэгээ болон онгоц хийж дуусаад байрлуулах ажил 11 сарын 20-нд бүрэн хийгдэж дуусна.	
Нийт дүн					3500.0₮		



Зyраг 11. Дyйцyүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөлт




1. Бригадын төв



2. Гooжyур хyдаг

Зyраг 12. Дyйцyүүлэн хамгаалах арга хэмжээ авч хэрэгжyүүлсэн талбай



3. Гоожуур худаг
Зураг 13. Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээ авч хэрэгжүүлсэн талбай



4. Гоожуур худаг



5. Бассейн байрлах хэсэг

Зураг 14. Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээ авч хэрэгжүүлсэн талбай



6. Бассейн байрлах хэсэг



7. Худгийн усны онгоц

Зураг 15. Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээ авч хэрэгжүүлж буй талбай



8. Худгийн усны онгоц

7. НҮҮЛГЭН ШИЛЖҮҮЛЭХ, НӨХӨН ОЛГОВОР ОЛГОХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТАЙЛАН

Гомдол, санал хүсэлтийг барагдуулах механизм:

Гомдол барагдуулах механизмын бүтэц, зохион байгуулалтыг загварчлахдаа дараах зарчмыг баримтлах ёстой. Үүнд:

- ◁ Төсөл хэрэгжих нутаг дэвсгэр дээр орших үйлдвэрийн ажиллагсад, оршин суугчдын гомдол хүсэлт бүрийг бүртгэн хүлээн авч, хүлээн авч байгаагаа эргэж мэдэгдэх бүртгэлийн ил тод системийг бий болгосон байх
- ◁ Гомдол хүсэлт бүр нь тухайн төслийн хамрах хүрээнд багтаж буй эсэх, гомдол нь үндэслэлтэй эсэхийг тогтоох
- ◁ Гомдолд тусгасан асуудлыг судлах, үүний тулд ижил төстэй гомдлыг шийдэж байсан туршлагын талаар мэдээллийг цуглуулах, гомдлыг төслийн хүрээнд шийдэх боломжтой эсэх, боломжтой тохиолдолд барагдуулах ямар шийдлүүд байгааг бусадтай ярьж зөвшилцдөг байх
- ◁ Хөндлөнгийн зөвлөх, гуравдагч этгээдийн оролцоотой/оролцоогүйгээр шийдэх арга замууд:
 - Төслийн удирдлагын хүрээнд дотоод шийдвэр гаргах журмын дагуу, эсвэл тогтоосон дэг ёс, шалгуур үзүүлэлтээр тухайн гомдолд хариу өгөх, мөн гомдлыг шийдвэрлээгүй тохиолдолд төслийн дээд удирдах байгууллагад гомдлоо илгээх боломжийг олгох
 - Гомдол гаргагч болон төсөл хэрэгжүүлэгч нэгж хамтран ярилцах замаар шийдлийг олох
 - Сайн дурын үндсэн дээр зөвшилцөн шийд гаргаж чадаагүй тохиолдолд хөндлөнгийн этгээдийн өгсөн шийдлийн санал дээр үндэслэн гомдлыг шийдэх
- ◁ Гомдлын мөрөөр авсан шийдэл, арга хэмжээг хянах, хариу мэдэгдсэн эсэхийг нягтлан шалгах хяналтын бүтцийг бий болгох
- ◁ Төсөл хэрэгжүүлэх нэгж, төсөл хэрэгжиж буй нутаг дэвсгэрийн ард иргэд, үйлдвэрийн газрын ажилтан, ажилчидтай гомдлын мөрөөр авч буй/авсан арга хэмжээний талаар мэдээлэл түгээх, гомдлыг хүлээн авах, шийдвэрлэх бүтэц, зохион байгуулалтыг сайжруулах талаар ард иргэдээс санал авах
- ◁ “Эхлэл Ургац Энержи” ХХК-ийн зөвшөөрлийн талбайд хамаарах Тарагт “ИХ” бууц нэртэй 000574828 тоот дугаартай Ө.Азжаргал иргэний өвөлжөөний газарт нөхөн олговор олгож нүүлгэн шилжүүлэх арга хэмжээг 2019-2020 онд авч хэрэгжүүлэн ажилласан. Нүүлгэн шилжүүлэх нөхөн олговор олгох арга хэмжээг дахин авч хэрэгжүүлэхгүй болсон.

8. ТҮҮХ, СОЁЛЫН ӨВИЙГ ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТАЙЛАН

Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний хүрээнд археологи, палеонтологи, түүх соёлын дурсгалт зүйлс бүртгэгдээгүй болно. 2023 онд үйл ажиллагаа явуулж буй талбайд археологи, палеонтологи, түүх соёлын дурсгалт зүйлсийн илэрч илрээгүй болно. Тиймээс энэ чиглэлийн үйл ажиллагаа, арга хэмжээ авагдаагүй.

Хавсралтаар Дундговь аймгийн Дэлгэрхангай сумын нутагт орших “Урд тарагт” нэртэй ашигт малтмалын хайгуулын XV-020375 тоот зөвшөөрөлтэй 3294.27 га талбайд хийсэн археологийн авран хамгаалах хайгуул судалгааны ажлын мэдээлэл болон Палеонтологийн тандан судалгааны тайлан дүгнэлтийг хавсаргав.

Хүснэгт 7. Төслийн бүсэд түүх соёлын, шинжлэх ухааны дурсгалт зүйлс илэрсэн үед хамгаалах арга

хэмжээ

Нөлөөлөлд өртөх түүх соёлын өвүүд	Хамгаалах арга хэмжээ	Арга хэмжээний цар, хэмжээ	Нэгжийн өртөг /мян.төг/	Нийт зардал /мян.төг/	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах стандарт, аргачлал
Газрын хэвлийг хөндөхөд археологийн ба палеонтологийн олдвор, түүх соёлын дурсгал өртөж болзошгүй	Олдвор илэрвэл тухайн үед нь орон нутгийн захиргаанд мэдэгдэж холбогдох арга хэмжээ авах	Төслийн талбайд	-	Төсөв зохиож хэрэгжүүлэх	Шаардлагатай үед	Соёлын өвийг хамгаалах тухай хуулийн 23.1, 27.8, 38.3 зэрэг заалтууд

9. ХИМИЙН БОДИСЫН ЭРСДЭЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТАЙЛАН

Урд тарагт уурхайн үйл ажиллагаанд химийн бодис ашигладаггүй. Тиймээс энэ чиглэлийн арга хэмжээ авагддаггүй болно. 2023 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд арга хэмжээ авагдахгүй гэж тусгагдсан болно.

10. ОСОЛ, ЭРСДЭЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТИЙН ТАЙЛАН

Хүснэгт 8. Осол эрсдэлийн менежментийн төлөвлөгөөний биелэлтийн тайлан

Болзошгүй аюул, осол сөрөг нөлөө	Урьдчилан сэргийлэх, хамгаалах арга хэмжээ	Арга хэмжээний цар, хэмжээ	Зардал мян.төг	Гүйэтгэл	Зураг
Санаатай болон санамсаргүй байдлаас гал гарах	<ul style="list-style-type: none"> - Гал унтраах хэрэгслээр уурхайг бүрэн хангах арга хэмжээ авах, галыг унтраах талаар тодорхой түвшинд бэлтгэлийг хангуулах - Жил бүр галын хорыг солих шаардлагагүй харин тухайн жилд 1 удаа цэнэглүүлсэн 	Уурхайн хэмжээнд	Галын хор 10 ширхэг * нэгж үнэ 30.0 = 300.0	10 ширхэг галын хорыг дахин цэнэглэж шаардлагатай цэгүүдэд байрлуулсан. Мөн галын хорны бүрэн бүтэн байдлыг байнгын ажиллагааг шалгаж ажилласан.	
Ажилчдын аюулгүй байдлыг хангах	<ul style="list-style-type: none"> - Ажилчдыг ажлын хувцас, хамгаалалтын тусгай хэрэгслээр (хөвөн даавуун материалаар хийсэн хувцас, резинэн хормогч, резинэн гутал, резинэн бээлий, хамгаалалтын нүдний шил, маск) хангах 	Үйл ажиллагааны турш	Үйл ажиллагааны зардалд	Жил бүр нийт 16 ажилчдыг нормын хувцас болон хамгаалах хэрэгсэлийг цаг тухай бүрт байнгын хангаж ажилласан.	
	<ul style="list-style-type: none"> - Ажилчдын байгаль орчны боловсролыг дээшлүүлж, хувь хүнээс үүдэлтэй бохирдол, аливаа гэмтэл ослыг бууруулах сургалт зохион байгуулах 	Жил бүр	Үйл ажиллагааны зардалд	Улаанбаатар хотод байрлах төв оффист 2023 оны 9 сард ажилчдын сургалтыг зохион байгуулсан.	

Гэнэтийн осол, гэмтэл, дэлбэрэлт	Барилга байгууламжийг газар хөдлөлийн бүсэд тохируулан хийцийг сонгох	Үйлдвэрийн барилгын ажлын үед	Үйл ажиллагааны зардалд	Уурхайн кемпийг үер ус газар хөдлөлт зэрэг байгалийн гамшигаас сэргийлэх зорилгоор өндөрлөг тэгш газарт байрлуулсан.	
	Осол эрсдэл үүссэн үед устгах арга хэмжээний төлөвлөгөөтэй байх	Үйл ажиллагааны турш	Үйл ажиллагааны зардалд	Онцгой байдлын газраас тухайн жилийн аваарь устгах төлөвлөгөөг батлуулан ажиллаж байна.	
	Байгаль орчин болон Хөдөлмөр хамгааллын гэх мэт орон тооны мэргэжилтэн авч хариуцуулж ажиллуулах	Үйл ажиллагааны турш	-	ХАБЭА-н ажилтан болон БО-ны мэргэжлийн дадлага туршлагатай хүмүүстэй	
Хүн, мал, амьтан, Ургамлын гоц халдварт өвчин	Байгаль орчин болон хөдөлмөр хамгааллын гэх мэт орон тооны мэргэжилтэн авч хариуцуулж ажиллуулах, Төслийн хэмжээнд болон орон нутгийн хүн амд гамшгийн аюулын тухай дохио, сэрэмжлүүлэх мэдээлэл хүргэх, зохицуулах, хяналт шинжилгээ, үнэлгээ хийх, Орон нутгийн болон улсын онцгой байдлын ерөнхий газартай хамтран ажиллах, үйл ажиллагаагаа уялдуулах, Үйл ажиллагааныхаа онцлогт зохицуулан гамшгаас хамгаалах орон тооны бус штаб, алба, мэргэжлийн анги байгуулах	Үйл ажиллаг ааны турш	ХАБЭА-н тухай хуулийн дагуу төслийн тухайн жилийн зардлын 1.5%-аас багагүй хөрөнгийг жил бүр төсөвлөх	ХАБЭА-н ажилтан болон БО-ны мэргэжилтэн сум орон нутгийн төр захиргааны төв байгууллагын бүхий л хүмүүстэй мэдээлэл холбооны талаар уялдаа холбоотой ажиллаж байна.	
Хүчтэй цасан- ба шороон шуурга					
Хүчтэй цасан ба шороон шуурга					
Ган, зуд, цөлжилт					
Гал түймэр					
Газар хөдлөл					
Үер					
Аянга					
Болзошгүй аюул, осолын нөлөөллийн зардал			300.0₮		

Болзошгүй аюул, осолын нөлөөллийн зардал 300'000 төгрөгийг зарцуулсан.

Болзошгүй осол эрсдэл

Болзошгүй осол аюулын үед авч хэрэгжүүлэх ажлын хүрээнд дараах үйл ажиллагааг авч хэрэгжүүлсэн.



Зураг 16. Аюулгүй ажиллагааны самбар



Зураг 17. Галын аюулгүй байдлын зааварчилгаа болон анхны тусламжийн самбар



Зураг 18. Нэг бүрийн хамгаалах хэрэгсэл шаардах орчин



Зураг 19. Нормын хувцас



Зураг 20. Гагнуурын үед хэрэглэх бээлий



Зураг 21. Ажын байранд галын хор байрлуулсан байдал



Зураг 22. ШТС-ын дэргэд галын хор байрлуулсан байдал

2023 онд ОБЕГ-ын “Үндэсний аврах бригадын захирагчийн орлогч, уул уурхайн аврах ангийн захирагчаар” жил бүрийн “Аюулын үед авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө”-г батлуулан ажилладаг.



Зураг 23. Аюулын үед авч хэрэгжүүлэх төлөвлөгөө



Зураг 24. Галын аюултай анхааруулах тэмдэг

Цугларах цэгийг сонгохдоо аюул багатай газрыг сонгох ба эндээс ажилчдыг бүртгэх, гүйцэтгэх ажил үүрэгт хуваарилах, хянах, нэгдсэн зохион байгуулалтанд оруулах ажлыг эхлүүлнэ. Төслийн тухайд цугларах цэгийг салхины зонхилох чиглэлийн дээд талд, газрын гадрагын рельефийн хувьд өндөрлөг газар, объектуудад ойр байдлыг тооцож, дараах байдлаар сонгосон.



Зураг 25. Цуглах цэг

11.ХОГ ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙН ТАЙЛАН

Тус төслийн үйл ажиллагааны хүрээнд бий болох хаягдлыг авч үзвэл, ахуйн хатуу хог хаягдал, уурхайн хотхоны хэрэгцээнээс хаягдах бохир ус (хоолны газар, усанд орох газар, ариун цэврийн өрөө гэх мэтээс), үйлдвэрийн техникийн үйл ажиллагаанаас үүсэх хаягдал ус, техникт ашигласан хаягдал тос, маслын хаягдал зэргээс бүрдэж байна.

Хатуу хог хаягдал: Тус төслийн үйл ажиллагааны хүрээнд ахуйн хэрэглээнээс гарсан хувинцар сав, шил, лааз, цаас, сав, баглаа боодол, асгарсан шатахуун, шатах тослох материалыг шингээж авсан цаас, алчуур, хүмүүсийн эдэлж хэрэглэж байсан зүйлс, техник тоног төхөөрөмжийн хаягдал сэлбэг хэрэгсэл (хаягдал төмөр, утас г.м) зэрэг зүйлс хатуу хог хаягдалд хамаарна. Төсөлд нийт 16 хүн ажиллах бөгөөд жилд 162 хоног өдөр ажиллана гэж тооцвол өдөрт 8 кг, сард 240 кг (16 хүн x 0.5 кг хатуу хог хаягдал/хоног x 30 хоног), жилд 1296 кг хог хаягдал гарах тооцоо байна. Энэ бол хүмүүсийн өдөр тутмын хэрэглээнээс гарах ахуйн хог хаягдлын тооцоо бөгөөд үүн дээр машин техникийн ШТМ, ашигласан тос маслын хаягдлыг тусгайлан хуримтлуулан жилд нэг удаа хаягдал тос, масло боловсруулах үйлвэрт гэрээ хийж тогтсон хугацаанд нийлүүлнэ.

Тус төслийн үйл ажиллагааны хүрээнд үүсэх ахуйн хог хаягдлыг тусгай зориулалтын саванд ангилан ялгаж (дахин ашиглаж боломжтой эсхээр нь), хатуу хог хаягдалд зориулан барьсан хашаа, хайс хамгаалалттай цэг эсвэл байранд (мал, амьтан орхооргүй, хөрс, усанд шууд шингэх боломжгүй хатуу бетонон хучилтай байх) хадгалах шаардлагатай. бөгөөд Хонгор сумын засаг даргын тамгын газартай байгуулсан гэрээний дагуу төвлөрсөн хогын цэгт зайлуулж булшлах шаардлагатай болно. Харин дахин ашиглах боломжтой хуванцар сав, шил, лааз, цаас болон хаягдал төмрийг ялган цуглуулж, хоёр дахь түүхий эд боловсруулах үйлдвэрт тушаах нь зүйтэй.

Хатуу хог хаягдлыг эмх замбараагүй хаях, буруу хадгалж, зайлуулсны улмаас байгаль орчны бүрэлдэхүүн хэсгүүд болох агаар, ус, хөрс, ургамлан нөмрөгг бохирдуулагч бодис тархаж, улмаар ажилчид болон төслийн талбай орчмын иргэдийн эрүүл мэндэд сөргөөр нөлөөлж болзошгүйг онцгойлон анхаарах шаардлагатай.

Хүснэгт 9. Хог, хаягдлын менежментийн арга хэмжээний зардал

Болзошгүй сөрөг нөлөөлөл	Нөлөөллийг бууруулах арга хэмжээ	Арга хэмжээний цар хүрээ	Нийт Зардал төг	Гүйцэтгэл	Зураг
Хог хаягдлыг тогтмол Зайлуулаагүйг ээс орчин бохирдох	2023 оны Хог хаягдлын гэрээг Дундговь аймгийн Дэлгэрхангай сумын ЗДТГ-тай байгуулах	Ордын хэмжээнд	Үйл ажиллагааны зардалд	Дэлгэрхангай сумын ЗДТГ-тай гэрээ байгуулсан. Хог хаягдлын төлбөрийг бүрэн төлсөн.	
Хог хаягдлыг эх үүсвэр дээр нь ангилан ялгаж, ангилан ялгасан хог хаягдлыг хоёрдогч түүхий эд хүлээн авах цэгт тушаах, хог хаягдлыг дахин ашиглах зэрэг 3R-ийн зарчмыг үйл ажиллагаандаа нэвтрүүлэх	Хог хаягдлыг эх үүсвэр дээр нь ангилан ялгаж, ангилан ялгасан хог хаягдлыг хоёрдогч түүхий эд хүлээн авах цэгт тушаах, хог хаягдлыг дахин ашиглах зэрэг 3R-ийн зарчмыг үйл ажиллагаандаа нэвтрүүлэх	Үйл Ажиллагааны турш	Үйл ажиллагааны зардалд	Хог хаягдалыг эх үүсвэр дээр нь ангилан ялгаж үйл ажиллагаа явуулж байна. 2020 онд ангилан ялгах хог хаягдлын савыг хийж үйл ажиллагаандаа нэвтрүүлсэн.	
Хог хаягдал хадгалах зориулалтын цэгт хогийн савыг 3-аас доошгүй төрлөөр ялгаж, тэмдэгжүүлсэн байх	Хог хаягдал хадгалах зориулалтын цэгт хогийн савыг 3-аас доошгүй төрлөөр ялгаж, тэмдэгжүүлсэн байх	Үйл ажиллагааны турш	Үйл ажиллагааны зардалд	Хог хаягдлыг 3 төрлөөр ангилан ялгаж байна.	

	Хаягдал ажилласан тосыг тусгай саванд цуглуулж 1тн хүрсэн тохиолдолд дахин боловсруулах үйлдвэрт өгөх	Үйл ажиллагааны турш	Үйл ажиллагааны зардалд	Хаягдал тос дахин ашигладаг “Эг Өргөө” ХХК-тай хаягдал тосоо нийлүүлэхээр гэрээ байгуулсан.	
	Бүх нийтийн цэвэрлэгээ хийх	Уурхайн талбай кемп орчимд	100.0	Уурхайн ростор 20/10 болсонтой холбоотой. Бүх нийтийн цэвэрлэгээг 10 хоногт 1 удаа хийж гүйцэтгэдэг болсон. 10-р сарын эцсийн байдлаар 20 удаа хийж гүйцэтгээд байна.	
	Ариутгал, цэвэрлэгээг хийж 14 хоногт 1 удаа хийж гүйцэтгэх	Халуун ус, нийтийн бие засах газар	360.0	Ариутгал цэвэрлэгээг 20 хоногт 1 хийж гүйцэтгэдэг болсон. Одоогоор 8 удаа хийж гүйцэтгээд байна.	
	Аюултай хог хаягдал үүсгэгчийн дугаар авах	Үйл ажиллагааны турш	Үйл ажиллагааны зардалд	Аюултай хог хаягдал үүсгэгч болон хог хаягдлын мэдээллийн санд бүртгэл үүсгэж бүртгэлийн дугаар авсан.	
Хог хаягдлыг менежментийн нийт зардал				460.0	

Хог хаягдлын менежментийн нийт зардалд **460'000** төгрөгийг зарцуулсан.

даа Хөгжлийн Банк

Огноо: 2023.04.13 17:42:20

Шилжүүлгийн мэдээлэл
Журналын №: 98193582

Огноо: 2023.04.13

ЭЛ УРГАЦ ЭНЕРЖИ ХХК

Дансны дугаар: 499276326	Нэр ЭХЛЭЛ УРГАЦ ЭНЕРЖИ ХХК	Дүн 50,000.00 MNT	Ханш 1.00
/ тавин мянган төгрөг /			
Банкны дугаар: 040000	Банкны нэр Худалдаа Хөгжлийн Банк	50,000.00 MNT	1.00
Дансны дугаар 475033524	Нэр СУВД-ЭРДЭНЭ СОДБААТАР		

Гүйцэтгэл:
Усны хаягдал усны дүгнэлт гаргуулсаны төлбөр

Танд баярлалаа

Энгийн баримтыг баталгаажуулсан
ЦООНЫ ТӨВ:

Зураг 28. Ус ашиглах дүгнэлт гаргуулсан төлбөр

Худалдаа Хөгжлийн Банк

Огноо: 2023.09.20 16:34:38

Шилжүүлгийн мэдээлэл
Журналын №: 121244157

Системийн огноо: 2023.09.20

Нэр: ЭХЛЭЛ УРГАЦ ЭНЕРЖИ ХХК

Илгээгч	Дансны дугаар: 499276326	Нэр ЭХЛЭЛ УРГАЦ ЭНЕРЖИ ХХК	Дүн 1,554,000.00 MNT	Ханш 1.00
/ нэг сая таван зуун тавин дөрвөн мянган төгрөг /				
Хүлээн авагч	Банкны дугаар: 040000	Банкны нэр Худалдаа Хөгжлийн Банк	1,554,000.00 MNT	1.00
	Дансны дугаар	Нэр		

Гүйцэтгэний утга:
ЕВ - 3230405517194-Үйлдвэрлэл, үйлчилгээний зориулалтаар ашигласан усны төлбөр-Д

Танд баярлалаа

Зураг 29. Ус ашигласны төлбөр

Хог хаягдлын мэдээллийн сан

Хог хаягдлын лавлах > Энгийн хог хаягдлын лавлах > Аюултай хог хаягдлын лавлах > Гаргах

Удирдах хуудас

Хэрэглэгч

Хог хаягдлын мэдээ

Эх үүсвэрээс гарах хог хаягдлын кодчилол

Аюултай хог хаягдал

Энгийн хог хаягдал

Мэдээллийн сангийн мэдээ бурагуулалт

Аж ахуйн нэгжийг бүртгэх бүртгэлийн хуудас

Аюултай хог хаягдал үүсгэгч болон тээвэрлэх, цуглуулах, дахин боловсруулах, устгах, экспортолох үйл ажиллагаа эрхлэх аж ахуйн нэгжийг бүртгэх бүртгэлийн хуудас

Бүртгэлийн мэдээлэл

Бүртгэлийн дугаар	Y-001851
Бүртгүүлсэн огноо	2023-11-08
Мэдээ оруулсан хэрэглэгчийн нэр	Дундговь аймгийн БОАЖГ - Ганцацэг

Аж ахуйн нэгжийг бүртгэх бүртгэлийн хуудас далгарнгүй харах хэсэг

1	Бүртгүүлэх зорилго	Үйл ажиллагаанаас аюултай хог хаягдал үүсдэг тул бүртгүүлэх
2	Аж ахуйн нэгжийн нэр	Эхлэл ургац энерги ХХК
3	Аж ахуйн нэгжийн бүртгэлийн дугаар	Улсын бүртгэлийн дугаар 9011222037

Зураг 30. Аюултай хог хаягдал үүсгэгчийн бүртгэлийн дугаар

<p>ДУНДГОВЬ АЙМГИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ГАЗАР 2023 ОНЫ УС АШИГЛАХ ДҮГНЭЛТ</p> <p>2023 оны 05 сарын 01-ны өдөр Дугаар № 04 Мандатогч хот</p> <p>1. Агаарын нэгж байгууламга, захирлын нар, хувьцаа, үнэмлэх, урсгал бүртгэлийн болон хөдөөгийн дураар, цэвэр усны "ХХК ДЭЛГЭРХАНГАЙ ЭНЕРЖИ ХХК-ийг үндэслэн, Сурбалзар дугаар-1, 13-р хороолол, нутагтээсээ гудамж 30-р байр, МТМ хөдөө, урсгал бүртгэлийн №011222037, регистрын №232394, Гудамж агаарын Ю Төмөрхүү, утас-8919109, 8919109 фанс. 2. Төслийн байршил, харьяалагдах өөр газар "Юс тархалт" нутгийн орда нь Дундговь аймгийн Дундговь суман хоёр байр, суман төлөөс бууга уршиг 24 нэгт оршино. Орон тавдун сув газартай хамаарна. 3. Төлөв баримтууламга: Энэс угнаа үнэмжлэх ХХК 4. Тусгай зөвшөөрлийн дураар болон галтбайр координат ДХУ: № MV-021285 Нийт талбай -121.14 X Y 104°30'20" 49°19' 104°38'46.1" 49°19' 104°38'46.1" 49°14" 104°30'20" 49°14"</p> <p>5. Хөдөөдөг уурт, татомол шийдвэрийн дагуу онооцоох урсгал бүртгэлийн нэгж байгууламга, захирлын нар, хувьцаа, үнэмлэх, урсгал бүртгэлийн болон хөдөөгийн дураар, цэвэр усны</p> <p>6. Хөдөөдөг уурт, татомол шийдвэрийн дагуу онооцоох урсгал бүртгэлийн нэгж байгууламга, захирлын нар, хувьцаа, үнэмлэх, урсгал бүртгэлийн болон хөдөөгийн дураар, цэвэр усны</p> <p>7. Хөдөөдөг уурт, татомол шийдвэрийн дагуу онооцоох урсгал бүртгэлийн нэгж байгууламга, захирлын нар, хувьцаа, үнэмлэх, урсгал бүртгэлийн болон хөдөөгийн дураар, цэвэр усны</p> <p>8. Усныг зураар, ивээх, хөдөөдөг уурт, татомол шийдвэрийн дагуу онооцоох урсгал бүртгэлийн нэгж байгууламга, захирлын нар, хувьцаа, үнэмлэх, урсгал бүртгэлийн болон хөдөөгийн дураар, цэвэр усны</p> <p>9. Усныг зураар, ивээх, хөдөөдөг уурт, татомол шийдвэрийн дагуу онооцоох урсгал бүртгэлийн нэгж байгууламга, захирлын нар, хувьцаа, үнэмлэх, урсгал бүртгэлийн болон хөдөөгийн дураар, цэвэр усны</p> <p>10. Усныг зураар, ивээх, хөдөөдөг уурт, татомол шийдвэрийн дагуу онооцоох урсгал бүртгэлийн нэгж байгууламга, захирлын нар, хувьцаа, үнэмлэх, урсгал бүртгэлийн болон хөдөөгийн дураар, цэвэр усны</p> <p>11. Байгаль орчны менежментийн төлөвлөгөө, нэгж байгууламга, захирлын нар, хувьцаа, үнэмлэх, урсгал бүртгэлийн болон хөдөөгийн дураар, цэвэр усны</p> <p>12. Оронд өндөр: Гомруунг үндэслэн хөдөөдөг уурт, татомол шийдвэрийн дагуу онооцоох урсгал бүртгэлийн нэгж байгууламга, захирлын нар, хувьцаа, үнэмлэх, урсгал бүртгэлийн болон хөдөөгийн дураар, цэвэр усны</p>	<p>1000кг, байгаль орчны, ногоон хөдөөдөг уурт, татомол шийдвэрийн дагуу онооцоох урсгал бүртгэлийн нэгж байгууламга, захирлын нар, хувьцаа, үнэмлэх, урсгал бүртгэлийн болон хөдөөгийн дураар, цэвэр усны</p> <p>14. Хөдөөдөг уурт, татомол шийдвэрийн дагуу онооцоох урсгал бүртгэлийн нэгж байгууламга, захирлын нар, хувьцаа, үнэмлэх, урсгал бүртгэлийн болон хөдөөгийн дураар, цэвэр усны</p> <p>15. Хөдөөдөг уурт, татомол шийдвэрийн дагуу онооцоох урсгал бүртгэлийн нэгж байгууламга, захирлын нар, хувьцаа, үнэмлэх, урсгал бүртгэлийн болон хөдөөгийн дураар, цэвэр усны</p> <p>16. Хөдөөдөг уурт, татомол шийдвэрийн дагуу онооцоох урсгал бүртгэлийн нэгж байгууламга, захирлын нар, хувьцаа, үнэмлэх, урсгал бүртгэлийн болон хөдөөгийн дураар, цэвэр усны</p> <p>17. Хөдөөдөг уурт, татомол шийдвэрийн дагуу онооцоох урсгал бүртгэлийн нэгж байгууламга, захирлын нар, хувьцаа, үнэмлэх, урсгал бүртгэлийн болон хөдөөгийн дураар, цэвэр усны</p>	<p>Өдрийн А-376 тоот тухайгаар - Зөвлөмжид заасан ахуйн тайлан, Ус ашиглалтын мэдээ тайланг 12-р сарын 20-нд Балтгай аймгийн Байгаль орчны, аялал жуулчлалын газарт ирүүлэх.</p> <p>ХЯНАСАН: БАЙГАЛЬ ОРЧНЫ АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ГАЗРЫН ДАРГА /Н.ГАНТУУГА/ БОЛОВСРУУЛСАН: БАЙГАЛЬ ОРЧНЫ АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ГАЗРЫН МЭРГЭЖИЛТЭН /Б.ЦЭРЭНСҮҮР/</p>
--	--	--

Зураг 31. Ус ашиглах дүгнэлт

<p>БАЙГАЛЬ ОРЧНЫ АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ГАЗАР 2023 ОНЫ УС АШИГЛАХ ДҮГНЭЛТ</p> <p>2023 оны 07 сарын 29 өдөр Дугаар 02 ХАШААТ.</p> <p>Нэг, Ерөнхий зуул Усны тухай хуулийн 26.4, 28.6, 28.7, 29.1-д заасны дагуу Дундговь аймгийн Дундговь суман "ХХК ДЭЛГЭРХАНГАЙ ЭНЕРЖИ ХХК" болон "ХХК ДЭЛГЭРХАНГАЙ ЭНЕРЖИ ХХК-ийн Ю ТӨМӨРХҮҮ" нар ус ашиглах талаар тохирсон 2023 оны 05 сарын 01-ны өдөрний 04 дугаартай ус ашиглах дүгнэлтийг үндэслэн. Ус ашиглах талаар төлөвлөгөө байгаль орчны менежментийн төлөвлөгөө, нэгж байгууламга, захирлын нар, хувьцаа, үнэмлэх, урсгал бүртгэлийн болон хөдөөгийн дураар, цэвэр усны</p> <p>Хөдөөдөг уурт, татомол шийдвэрийн дагуу онооцоох урсгал бүртгэлийн нэгж байгууламга, захирлын нар, хувьцаа, үнэмлэх, урсгал бүртгэлийн болон хөдөөгийн дураар, цэвэр усны</p> <p>2.1. Ус ашиглах зориулалт 2.2. Ашиглах усны хэмжээ 2.2.1. үнд-8847 2.2.2. Үнд-8847 2.2.3. Үнд-8847 2.2.3.1. үнд-8847 м³/ногоон байгууламжийн урсгалтай 2.2.4. үнд-8847 2.2.4. үнд-8847 2.2.4. үнд-8847 2.3. Ус ашигласны нийт төлбөрийн хэмжээ - 1564300 /нэг сан таван зуун таван дөрвөн мянга тэсрэг /ус, рашданы нөөц ашигласны төлбөрийн хэмжээ 2.4. Хаягдал усан дахь нэгж бохирдуулах бодист ногдох төлбөрийн хэмжээ /ус бохирдуулахын төлбөр/ 2.5. дараах мэдээлэлгүйг Дундговь аймгийн Төрийн сан Банкны 10080000944 тоот дансанд төвлөрүүлнэ</p>	<p>Гурав, Талуудын эрх, үүрэг Гэрээ байгуулах талууд нь Усны тухай хуулийн 7.5, 10.1.18, 13.1.1, 13.1.6, 18.1.4, 19.1.2, 19.1.4, 20.1, 30.1, 30.2, 31.1-д заасан эрх эдийн, үүрэг хүлээн Дүрвэ, Буцаа 4.1. Гэрээ нь талууд гарын үсэг зурж, тамга, тэмдэг дарга багтаахаар биедөө эдийн хөрөнгийн төлбөр болно 4.2. Ус ашиглах дүгнэлт, ус ашиглах зөвшөөрөл, хаягдал усны талварыг хүмүүс, хаягдал ус зайлуулах зөвшөөрөл нь гэрээний салшгүй хэсэг байна. 4.3. Гэрээний биеэнтэйг ил бүр дүгнэж, тасдагдал үйлдэнэ. 4.4. Талуудын тохирсонлоор гэрээнд нэмэгдэл оруулж болох ба бичгээр 4.5. Гэрээ дээр дараасан үндэслэлээр хувиарнаас нь өөрөд шилжнэ болно. 4.5.1 ашиглах байгаа усны эх үүсвэр тусгай хөдөөдөг уурт, татомол шийдвэрийн дагуу онооцоох урсгал бүртгэлийн нэгж байгууламга, захирлын нар, хувьцаа, үнэмлэх, урсгал бүртгэлийн болон хөдөөгийн дураар, цэвэр усны 4.5.2. нь нэг тал тасдагдал болно. 4.6. Талуудын хооронд үүссэн маргааныг эдийн хөрөнгийн шийдвэрлэхийг эсэмжлэх бөгөөд эс зөвшөөрөл холбогдох шалны шүүхэд шийдвэрлүүлнэ.</p> <p>ГЭРЭЭ БАЙГУУЛСАН: Ус ашиглагч/Талуудын эрх, үүрэг /ХХК ДЭЛГЭРХАНГАЙ ЭНЕРЖИ ХХК-ийн Ю ТӨМӨРХҮҮ/ Хаяг: Дундговь аймгийн Дундговь суман Харилцах утас:89202893</p> <p>Ус ашигласны үндэслэл Ус ашигласны үндэслэл /ХХК ДЭЛГЭРХАНГАЙ ЭНЕРЖИ ХХК-ийн Ю ТӨМӨРХҮҮ/ Хаяг: Улаанбаатар хот Харилцах утас:</p>
--	--

Зураг 32. Ус ашиглах гэрээ

<p>“ЭГ ӨРГӨӨ” ХХК Монгол улс, Солонго Хайрхан дүүрэг, 32-р хороо, 10-228 тоот, Утас: 88110506, 80044141 E-мэйл: egorgoo@net.rp.mn</p> <p>“ХӨГ ДАВГАДАЛ АВАХ ГЭРЭЭ”</p> <p>2022 оны 05 сарын 22-ны өдөр № 2022092201 Улаанбаатар хот</p> <p>Энэуу гэрээ (давцаагч Гэрээ) гэрээ-нэр талаас “ЭГ ӨРГӨӨ ХХК” (давцаагч “Хөдөөдөг уурт, татомол шийдвэрийн дагуу онооцоох урсгал бүртгэлийн нэгж байгууламга, захирлын нар, хувьцаа, үнэмлэх, урсгал бүртгэлийн болон хөдөөгийн дураар, цэвэр усны</p> <p>НЭГ, НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ 1.1. Энэуу гэрээний зорилго нь Нийлүүлэгч тал нь Хүлээн авагчид авчигдсан тос, масло, гадаргын шилжлэг гэрээ хаягдалын дахин ашиглах зорилгоор нийлүүлэгч, талуудын эдийн хөрөнгийн төлбөр, хаягдал усны талварыг хүмүүс, хаягдал ус зайлуулах зөвшөөрөл нь гэрээний салшгүй хэсэг байна. ХӨӨР, ГЭРЭЭНИЙ ГӨЛ НӨХЦӨЛ 2.1. Нийлүүлэгч нь дараах хаягдал нийлүүлнэ. №/ Нийлүүлэгч материалын Хэмжээ нэгж, м³ /га /сүүлэн/ 1. Хүлээн авагчид авчигдсан тос, масло - 2. Гадаргын шилжлэг - 2.2. Талууд бүтээгдэхүүн нийлүүлэх хувиарын дахиад байгуулах тохиролдоон. Нийлүүлэгч хувиар: 2022.09.22-2023.12.31</p>	<p>ГУРАВ, НИЙЛҮҮЛЭГЧИЙН ЭРХ, ҮҮРЭГ 3.1. Нийлүүлэгч нь гэрээнд зааснаар хаягдал тос, тосгооны материалыг хүлээн авагчид нийлүүлнэ.</p> <p>ДЭРВЭ, ЗАХИАЛАГЧИЙН ЭРХ, ҮҮРЭГ 4.1. Гэрээнд заасан нөхцөлөөр ашиглана. 4.2. Хүлээн авагч нь хаягдал тос, тосгооны материалыг үйлдвэрлэлийн ажиллагаанд ашиглана. Байгаль орчныд асвараа байр уургай. ТАВ, ЛУСАД 5.1. Энэуу гэрээ Хөг мөдлын тухай хуулийн шаардлага болгон байгуулсан бөгөөд гэрээ зорилгоо биелүүлэх, тайлбарлахад Хөг мөдлын тухай хуулийг хэрэглэнэ. 5.2. Энэуу гэрээнд талууд харилцан тохирсонлоор нэмэгдэл оруулж болох бөгөөд, өөрөөрөө бичгээр үйлдэнэ, талуудын эрх бүрэн төлөөлөн гарын үсэг зурж багтаахаарна. 5.3. Энэуу гэрээний талууд нь гэрээгээр олгосон эрх, үүрэг мөчөл талын бичгээр олгосон зөвшөөрөлгүйгэр шийдвэрлэхийг хориглоно. 5.4. Энэуу гэрээ үйлдэнэ бөгөөд мөчөл гэрээний эрх нэг заагаа эрх бүхий байгууллагын хаягдварууд хүчин төгөлдөр бүртгэлийн дагуу гэрээний бүрэлдээлтэй үйлдэнэ. 5.5. Энэуу гэрээ нь авчиргаа гэрээнд өгөгдөх эрх, үүрэг, харилцааг үүсгэнэ. 5.6. Энэуу гэрээ Монгол улс дотоод тухай үйлдэнэ ба Тал тус бүр нэг хүмүүн хамаарна. 5.7. Энэ гэрээнд Талууд гарын үсэг зурснаар хүчин төгөлдөр болно. 5.8. Энэуу гэрээ нь Захиргааны бүтээгдэхүүн бүрэн хүлээн авснаар дууснаар болно.</p> <p>ГЭРЭЭ БАЙГУУЛСАН: НИЙЛҮҮЛЭГЧИЙН ТӨЛӨВЛӨГ: ХХК ДЭЛГЭРХАНГАЙ ЭНЕРЖИ ХХК-ийн Ю ТӨМӨРХҮҮ Хаяг: Улаанбаатар хот Сүхбаатар дүүрэг 1-р хороо Алтанхай суман гудамж 32-р байр МТМ хөдөөдөг уурт, татомол шийдвэрийн дагуу онооцоох урсгал бүртгэлийн нэгж байгууламга, захирлын нар, хувьцаа, үнэмлэх, урсгал бүртгэлийн болон хөдөөгийн дураар, цэвэр усны Утас: 978 - 31653</p> <p>ХҮЛЭЭН АВАГЧИЙН ТӨЛӨВЛӨГ: “ЭГ ӨРГӨӨ” ХХК-ийн Дарга Хаяг: Улаанбаатар хот Хайрхан дүүрэг 32-р хороо 10-228 тоот Утас: 88110506, 80044141</p>
--	--

Зураг 33. “Эг Өргөө” ХХК-тай хаягдал тосоо нийлүүлэхээр байгуулсан гэрээ

12.ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨР

“Байгаль орчныг хамгаалах тухай” хуулийн 3.1 дүгээр зүйл, “Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай” хуульд зааснаар төслийг хэрэгжүүлэх явцад төлөөс байгаль орчинд учруулах сөрөг нөлөөллийг тухай бүр илрүүлэх, түүнийг бууруулах, арилгах зорилгоор байгаль орчны төлөв байдал, тодорхой орон зайд, тодорхой хугацааны дотор, тодорхой давтамжтайгаар ажиглалт, хэмжилт, хяналт явуулах үйл ажиллагааны удирдамжийг орчны хяналт-шинжилгээний хөтөлбөр гэж нэрлэх бөгөөд энэ нь төсөл хэрэгжиж буй бүс нутагт гарч болзошгүй өөрчлөлтүүдийг эрт тодорхойлох, сөрөг нөлөөллийг бууруулах, үйл ажиллагааны үр дүнг тайлагнах, авч хэрэгжүүлэх арга хэмжээний үндэслэлийг боловсруулах, орон нутгийн захиргаа, хяналтын байгууллага, нутгийн оршин суугчдад байгаль орчин, амьдрах орчны өөрчлөлийн талаар бодит мэдээлэл өгөх үндсэн зорилготой.

Дундговь аймгийн Дэлгэрхангай сумын нутаг дэвсгэрт байрлах 21268А тоот ашиглалтын тусгай зөвшөөрөл бүхий “Урд тарагт гөлтгөний орд” төслийг хэрэгжүүлэгч “Эхлэл Ургац Энержи” ХХК-ий 2023 оны Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийг БОАЖЯ-ны харьяа Байгаль орчны судалгаа шинжилгээний төв хийж гүйцэтгэсэн.

Хүснэгт 10. ОХШХ-ийн шинжилгээний төрөл

№	Шинжилгээний төрөл	Дээжний тоо	Нэгж үнэ /мян.төг/	Нийт үнэ /мян.төг/
Хөрс	Агрохимийн шинжилгээ	7	55.0	385.0
	Микробиологийн шинжилгээ	2	40.0	80.0
	Хүнд металлын шинжилгээ	7	65.0	455.0
Гадаргын ус	Цэвэр усны химийн шинжилгээ	1	49.0	49.0
	Хүнд металлын шинжилгээ	1	78.0	78.0
Агаар	PM 10	1	50.0	50.0
Дээжний бэлтгэл	Дээж авах болон дээжний бэлтгэл	11	30.0	330.0
Нийт				1427.0

13.УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТАЙЛАН

Жил бүр гүйцэтгэх ажлын хэмжээ болон зардлыг байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөнд тусгаж ажилласан.

Байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөний гүйцэтгэлд хяналт шинжилгээ хийлгэсэн дүнг заасан хугацаанд холбогдох байгууллагад хүргэж тайлагнаж байна.

Орон нутгийн төр захиргааны болон бусад бусад байгууллагаас тавигдах нэмэлт шаардлагыг заасан цаг хугацаанд нь биелүүлэн чанд мөрдөж ажиллаж байна.

Байгалийн нөөц баялгийг зохистой ашиглах, байгаль орчныг хамгаалах тухай хууль тогтоомжийн биелэлтийг хангах асуудлаар орон нутгийн төр захиргааны байгууллага болон эрх бүхий ажилтнуудтай байнга харилцан хамтарч ажиллаж байна.

Ерөнхий үнэлгээнд заасан чиглэл, болзлоос өөр үйл ажиллагаа явуулах болон үйлдвэрлэлийг өргөтгөх, тоног төхөөрөмжийг шинэчлэх бүрд ерөнхий үнэлгээнд хамрагдаж байна.

Хүснэгт 12. Удирдлага зохион байгуулалтын хэмжээнд хийгдсэн ажлын тайлан

Д/д	Төлөвлөсөн арга хэмжээ	Төсөв /мян.төг/	Хэрэгжүүлэх хуваарь			Нийт Зардал мян.төг	Гүйцэтгэл	Тайлбар
			2023 он					
			4 сар	5-6 сар	7-9 сар			
1.	БОНБҮ болон БОХТ, ОХШХ-т заасан сөрөг нөлөөллийг бууруулах зөвлөмжүүдийг үйл ажиллагаандаа тусгаж хэрэгжүүлэх	Үйл ажиллагааны зардалд тусгагдсан.	+	+	+	ОХШХ-н зардалд	2023 оны ОХШХ-ийн тайланг БОАЖЯ-ны Байгаль орчны судалгаа шинжилгээний төв байгууллага хийж гүйцэтгэсэн.	
2.	Байгаль орчны холбогдолтой шинээр гарсан хууль, тогтоомж, стандартыг уурхайн удирдлагуудад танилцуула		-	-	+	Үйл ажиллагааны зардалд	Эхлэл Ургац Энержи ХХК-ны Улаанбаатар хотод байрлах төв оффист 2023 оны 9 сард сургалтыг зохион байгуулсан.	

3.	Байгаль орчин, нөхөн сэргээлтийн чиглэлээрх мэдээ, мэдээллээр самбаруудыг тогтмол шинэчлэж байх			+		Үйл ажиллагааны зардалд	Байгаль орчин хог хаягдлын ангилал болон зөв зохистой хадшалах арга зүйн мэдээлэлийг шинэчлэн байрлуулсан.	
4.	Нийт ажилчдад байгаль орчин хамгаалах, нөхөн сэргээлтийн чиглэлээр сургалт хийх		+	-	-	Үйл ажиллагааны зардалд	Аюулгүй ажиллагаа болон байгаль орчинд нөлөөлөх сөрөг нөлөөллийг буруулах зорилгоор 2023 оны 9-р сард байгаль орчин ХАБЭА-н сургалт орсон.	
5.	Нийгмийн хариуцлагын хүрээнд уурхайн ойролцоо байрлах айлуудын өвөлжөөг засварлаж, дахин ашиглах боломжтой болгох		-	-	+	2000.0	Уурхайн ойролцоо амьдардаг малчдын хүсэлтээр уурхайн тоног төхөөрөмжийг ашиглан өвөлжөөг засварлаж, дахин ашиглах боломжтой болгон хүлээлгэж өгсөн.	
6.	2023 оны Байгаль орчны аудитын ажил хийлгэх		-	-	+	15000.0	2023 оны Байгаль орчны аудитын ажлыг “Эковишн” ХХК-аар хийж гүйцэтгүүлсэн.	
Нийт төсөв		-				17000.0₮		

Удирдлага зохион байгуулалтын зардалд 15 000 000 төгрөгийг зарцуулсан.



Зураг 34. Өвөлжөөг засварлаж буй үйл явц



Зураг 35. Өвөлжөөг засварлаж буй үйл явц

14. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ХУВААРЬ

Байгаль хамгаалах төлөвлөгөөг төсөл хэрэгжих хугацааны туршид хэрэгжүүлнэ. Төлөвлөгөөг хэрэгжүүлэхдээ дараах хуваарийг мөрдөх нь зүйтэй.

“Эхлэл ургац энерги” ХХК нь байгаль орчны төлөв байдалд хийсэн явцын хяналт шинжилгээг үндэслэн тухайн бодит нөхцөл байдалд нийцүүлэн төлөвлөгөөг жил бүр сайжруулан шинэчилж байх үүрэг хүлээнэ.

Байгаль орчны төлөвлөгөөг хэрэгжүүлэхдээ Дундговь аймгийн Дэлгэрхангай сумын байгаль орчны албатай нягт хамтран ажиллах ба төлөвлөгөөний хэрэгжилтийн талаар тогтоосон хугацаанд тайланг гаргаж мэдээлж байна. Төлөвлөгөөний хэрэгжилтэд төслийн баг байнга хяналт тавьж ажилласан.

Хүснэгт 13. Олон нийтэд тайлагнасан хуваарь

БОМТ хэрэгжилтийг тайлагнах, хэлэлцүүлэх байгууллагууд	Тайлагнах, хэлэлцүүлэх хэлбэр	Мэдээллийн агуулга	Хугацааны тов	Хэлэлцүүлгээр санал авах чиглэл	Зохион байгуулах газар	Төсөв /мян.төг/	Зураг
Сумын иргэд, засаг дарга болон иргэдийн хурал	Тухайн жилийн сумын иргэдийн нийтийн хуралд үйл ажиллагаа танилцуулах	Үйл ажиллагаа болон БОМТөлөвлөгөөний хэрэгжилтийн талаар	Жилд нэг удаа	Төслийн үйл ажиллагаатай холбоотой	2023 оны 10-р сард сум багийн Иргэдийн нийтийн хуралд уурхайн үйл ажиллагаа болон байгаль орчны чиглэлээр авч хэрэгжүүлж буй ажлуудыг танилцуулсан	500.0	
Дундговь аймгийн БОАЖГ-т төлөвлөгөө танилцуулах	Батлагдсан төлөвлөгөө хэвлэмэл байдлаар хүргүүлэх	Тухайн жилийн менежментийн төлөвлөгөө	Жилд нэг удаа	БОАЖГ-аас хийж гүйцэтгэх ажлын чиглэл авах	2023 оны БОМТөлөвлөгөөг 4-р сард батлагдсан даруйд Дундговь аймгийн БОАЖГ-т хүргүүлсэн.		

2023 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийн тайлан	Тайлангийн дүгнүүлэх	2023 оны тайлан	2023 оны 11-р сарын 1	Аймгийн комиссоор хэлэлцүүлэх	БОАЖЯ	 
	Тайлан батлуулах	2023 оны тайлан	2023 оны 2-р сарын 15-ны дотор	БОАЖЯ-ны ХБОБНУГ		
Нийт						500.0

Олон нийтэд тайлагнах үйл ажиллагаа

2023 оны 9-р сарын 29, 10-р сарын 1,2,3,4-нд сум багийн Иргэдийн нийтийн хуралд уурхайн үйл ажиллагаа болон байгаль орчны чиглэлээр авч хэрэгжүүлж буй ажлуудыг танилцуулах, иргэдийн санал хүсэлтийг авах тээврийн чиглэл маршрутыг өөрчлөх сөрөг нөлөөллийг бууруулах талаар иргэдтэй уулзаж ярилцсан. Иргэдэд төрийн болон хувийн байгууллагуудын хамтран ажиллах буй талаар хяналт шалгалт болон шаардлагын талаар мөн таниулж мэдээлэл өгсөн.





Зураг 36. Иргэдийн нийтийн хурлаар уурхайн үйл ажиллагааг тайлагнаж буй байдал

БАТЛАВ: ХҮРЭЭЛЭН БУЙ ОРЧНЫ БОДЛОГО ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ДАРГА		Б. БУЯННЭМЭХ
ЗӨВШӨӨРЧ, ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮҮРЭГ ХҮЛЭЭСЭН "ЭХЛЭЛ УРГАЦ ЭНЕРЖИ" ХХК ЗАХИРАЛ		Ю. ТӨМӨРХҮҮ
"ЭХЛЭЛ УРГАЦ ЭНЕРЖИ" ХХК НИЙ ДУНДГОВЬ АЙМАГ, ДЭЛГЭРХАНГАЙ СУМЫН НУТАГ ДЭВСГЭРТ ХЭРЭГЖИНЭ "УРД ТАРАГТЫН ГӨЛТГӨНИЙН ОРДЫГ ИЛ АРГААР АШИГЛАХ" ТӨСӨЛ ТӨСЛИЙН 2023 ОНД ХЭРЭГЖҮҮЛЭХ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ		
АШИГТ МАЛТМАЛЫН ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙН ДУГААР: XV-020375 АЖ АХУЙН НЭГЖИЙН РЕГИСТРИЙН ДУГААР: 5353564		
		
ХЯНАСАН: ХБОБЗГ-ЫН АХЛАХ ШИНЖЭЭЧ		Ц. ЖАРГАЛНЭМЭХ
БОЛОВСРУУЛСАН: "ЭХЛЭЛ УРГАЦ ЭНЕРЖИ" ХХК БАЙГАЛЬ ОРЧНЫ МЭРГЭЖИЛТЭН		С. СУВД-ЭРДЭНЭ
2023 ОН		

Зураг 37. 2023 оны Байгаль орчны менежментийн батлагдсан төлөвлөгөө

2023 оноос эхлэн БОМТ-ний биелэлтийг цахим байдлаар хүлээн авч байгаатай холбоотой компанийн цахим хаягийг үүсгэж тайлан цахим хэлбэрээр илгээх боломжтой болсон.



Зураг 38. *Ес.тп* цахим мэдээллийн сан

15. АШИГЛАСАН МАТЕРИАЛ

1. Төслийн Техник эдийн засгийн үндэслэл
2. Төслийн Байгаль орчинд нөлөөлөх байдлын ерөнхий үнэлгээгээний дүгнэлт
3. Төслийн Байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээгээний тайлан
4. Төслийн 2023 оны уулын ажлын тайлан
5. Байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулах, хянан батлах, тайлагнах журам / БОАЖЯ-ны сайдын 2019.10.29-ны өдрийн А-618 дугаар тушаал/
6. Уул уурхайн үйл ажиллагааны улмаас эвдрэлд орсон газарт техникийн болон биологийн нөхөн сэргээлт хийх аргачлал /БОАЖ-ын сайдын 2009.12.29-ний өдрийн 417 дугаар тушаал/
7. Байгаль орчин ногоон хөгжлийн яамны вэб сайт – www.met.gov.mn
8. Эрдэс баялаг, эрчим хүчний яамны вэб сайт – www.mmre.gov.mn
9. Ашигт малтмалын газрын вэб сайт – www.mrpm.gov.mn
10. Эрхзүйн мэдээллийн сайт – www.legalinfo.mn
11. Дундговь аймгийн вэб сайт – www.dundgovi.gov.mn



“ЭХЛЭЛ УРГАЦ ЭНЕРЖИ” ХХК-ИЙН ДУНДГОВЬ АЙМГИЙН ДЭЛГЭРХАНГАЙ
СУМЫН НУТАГТ ОРШИХ “УРД ТАРАГТ” НЭРТЭЙ XV-020375 ТООТ (3294.27ГА)
ХАЙГУУЛЫН ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛТЭЙ ТАЛБАЙД ЯВУУЛСАН
ПАЛЕОНТОЛОГИЙН ТАНДАН СУДАЛГААНЫ ТАЙЛАН ДҮГНЭЛТ



Тайлан бичсэн :

Г. Сэрсмаа / Ph. D /

Ж. Ундарьяа / Ph. D /

Улаанбаатар хот 2018 он

ОРШИЛ

“Соёлын өвийг хамгаалах тухай” Монгол улсын хуулийн 2014 оны 5 сарын 15 ны өдрийн шинэчлэсэн найруулгын 5.1.1; 6.1.5; 16.7.1; 17.1.3,4; 27.2; 28-р зүйл, 38.2,3; 60.1.10-д заасны дагуу газрын хэвлийг эзэмших ашиглахад палеонтологийн хайгуул тандан судалгааны ажлыг хийлгэх шаардлагатай байдаг. Уг хуулийн зорилго нь соёлын өвийг эрэн сурвалжлах, бүртгэх, судалж шинжлэх, зэрэглэл тогтоох, үнэлэх, хадгалж хамгаалах, сурталчлах, сэргээн засварлах, өвлүүлэн уламжлуулах, өмчлөх, эзэмших, ашиглахтай холбогдсон харилцааг зохицуулахад оршино. Эртний хүн, эртний амьтан, бичил биетэн, ургамлын чулуужсан олдвор, ул мөр, тэдгээрийг агуулсан олдворт газар нь түүх соёлын дурсгалт зүйлд хамаарна.

Мөн БСШУ-ны сайдын 2015 оны А141 тоот тушаалаар “Соёлын өвийн судалгаа хийх журам” батлагдсан.

Дээрхи хууль, журмын дагуу Монгол улсын нутаг дэвсгэрийн хэмжээнд үйлдвэрлэлийн эзэмшилд орж буй талбай газарт эртний амьтан ургамлын /палеонтологийн/ хайгуул тандан судалгааны ажлыг явуулж, тайлан дүгнэлтийг холбогдох байгууллагуудад албан ёсоор шилжүүлэх ажлыг судалгаа хийх зөвшөөрөл бүхий мэргэжлийн байгууллагууд хийж байна.

Судалгааны зорилго:

Монгол улсын Соёлын өвийн тухай хуулинд “Хот суурин, барилга байгууламж барих, шинээр зам тавих, усан цахилгаан станц байгуулах, ашигт малтмалын хайгуул хийх, ашиглах зэрэг аж ахуйн үйл ажиллагаа явуулахад зориулан газар олгоход палеонтологийн мэргэжлийн байгууллагаар урьдчилсан хайгуул, судалгаа хийлгэж зөвшөөрөл” авах талаар заалт, хууль тогтоомжийг үндэслэн захиалагч “Монполимет” ХХК, гүйцэтгэгч ШУТИС, ГУУС-ийн Стратиграфи-Палеонтологийн судалгааны төвийн хооронд байгуулсан 2018 оны 05 сарын 01-ны өдрийн гэрээний дагуу “Эхлэл ургац энерги” ХХК-ийн Дундговь аймгийн Дэлгэрхангай сумын нутагт орших “Урд тарагт” нэртэй XV-020375 тоот (3294.27га) хайгуулын тусгай зөвшөөрөлтэй талбайд палеонтологийн хайгуул, тандан судалгаа явуулж, эртний амьтан ургамлын олдвор, олдворт газар, илэрч болох магадлал буй эсэхэд үнэлэлт дүгнэлт гаргахад судалгааны зорилго чиглэгдсэн болно.

Зохион байгуулалт:

Гүйцэтгэгч талаас ШУТИС, ГУУС-ийн Стратиграфи-палеонтологийн судалгааны төвийн судлаач доктор Г. Сэрсмаа, доктор Ж. Ундарьяа нар 2018 оны 05-р сарын 06 наас 8- ны өдрүүдэд уг талбайд палеонтологийн хайгуул, тандан судалгаа хийж, ажиглалтын

цэгүүдэд координат авч, чулуулгийн бичиглэлийг товч бичиж, гэрэл зургаар баримтжуулан гүйцэтгэв.

Палеонтологийн ажлын үе шат, арга аргачлал:

“Эхлэл ургац энерги” ХХК-ны Дундговь аймгийн Дэлгэрхангай сумын нутагт орших “Урд тарагт” нэртэй XV-020375 тоот (3294.27га) хайгуулын тусгай зөвшөөрөлтэй талбайд палеонтологийн хайгуул, тандан судалгааны ажлыг соёлын өвийн судалгаа хийх журам, геологийн зураглал хийх зааварт тавигдах шаардлагыг мөрдлөг болгон ажиллаж 3 үе шаттайгаар гүйцэтгэв.

Бэлтгэл ажлын үед тусгай зөвшөөрлийн талбайд урьд өмнө нь хийгдсэн янз бүрийн шатны судалгаануудын мэдээллийг нэгтгэн үзэж, хурдсуудын хил заагийг тодотгон, геологийн биетүүдийн орон зайн байршил, хэмжээ үе давхаргыг тогтоосон болно. Өмнөх судлаачдын тайланд бичигдсэн хурдсын хил заагийг 1:100000 масштабтай байр зүйн зурагт буулгаж, түүн дээрээ тулгуурлан хээрийн ажлын хөтөлбөрийг боловсруулав.

Хээрийн судалгааны үед 1:100000 байр зүйн зураг, 1:50000, 1:200000-ны масштабтай геологийн зураг, агаар, сансрын зургийн тайлалт ашиглан палеонтологийн олдвор, олдворт газрыг илрүүлэх хайгуул, тандан судалгааны ажлыг хийж, ажиглалтын цэг бүрд координатыг тэмдэглэн, фото зургаар баримтжуулж, чулуулгийн бичиглэлийг хийсэн болно.

Суурин боловсруулалтын үед судалгааны ажлын тайлан бичиж, соёлын өвийн талаас нөлөөлөх нөлөөлөлд дүгнэлт хийв.

Судалгааны үр дүн:

“Эхлэл ургац энерги” ХХК-ны Дундговь аймгийн Дэлгэрхангай сумын нутагт орших “Урд тарагт” нэртэй XV-020375 тоот (3294.27га) хайгуулын тусгай зөвшөөрөлтэй талбайд цэрд палеогений тунамал хурдас тархсан байсан боловч палеонтологийн хайгуул, тандан судалгааны ажлыг хийхэд гадаргууд үндсэн илэрц гарш муутай тул эртний амьтан, ургамлын чулуужсан үлдвэр илэрсэнгүй.

ТАЛБАЙН ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

Хайгуулын талбай нь Улаанбаатар хотоос урагш 460 км, Мандалговь хотоос баруун урагш 180 км, Дундговь аймгийн Дэлгэрхангай сумын төвөөс баруун урагш 35 км, Улаанбаатар-Даланзадгадыг холбосон хатуу хучилттай замаас баруун урагш 100 км зайд оршино.

Хүснэгт №1

Д.д	Уртраг			Өргөрөг		
	град	мин	сек	град	мин	сек
1	104 ⁰	28'	46.1"	45 ⁰	1'	51.5"
2	104 ⁰	33'	33"	45 ⁰	1'	51.5"
3	104 ⁰	33'	33"	44 ⁰	59'	1.52"
4	104 ⁰	28'	46.1"	44 ⁰	59'	1.52"
Талбайн хэмжээ, га				3'294.27		

“Урд тарагт” нэртэй XV-020375 тоот (3294.27га) хайгуулын тусгай

зөвшөөрөлтэй талбайн солбицол



Зураг 1. Дундговь аймгийн Дэлгэрхангай сумын нутагт орших “Урд тарагт” нэртэй XV-020375 тоот (3294.27га) хайгуулын тусгай зөвшөөрөлтэй талбайн байршил зург.

ГЕОЛОГИЙН СУДАЛГААНЫ ТҮҮХ

Судалгааны ба түүний зэргэлдээ талбай нь геологийн судалгааны хувьд 18-р зуунаас эхтэй бөгөөд 1871-1875 онд Н.М.Пржевальский, 1938-1952 онуудад М.В.Певцов, А.В.Обручев, А.А.Чернов, П.К.Козлов, И.А.Ефремов, В.С.Волхонин нарын судлаачид голчлон хэсэгчилсэн маршрутын, геологийн ба газарзүйн зан заншлын судалгааны ажлууд хийж байжээ.


Анхны геологийн төрөлжсөн судалгаа болох 1:200 000-ны масштабын геологийн зураглалын ажлыг 1953 онд Б.И.Данилов, Л.И.Кочетов, В.И.Ширяев нарын удирдлагаар Дэлгэрхангай уулын орчимд хийгджээ. Энэ ажил нь дүүргийн газрын тосны хэтийн төлөвийг үнэлэх зорилготой хийгдсэн боловч дүүргийн ашигт малтмалын тэргүүн эгнээнд Тарагт худгийн районд тархсан улаан өнгийн шаварлаг хурдсанд агуулагдах гөлтгөнө болохыг тэмдэглэсэн байдаг. Үүний дараа 1958 онд М.М.Михайловын удирдсан 280-р анги Тарагт-1 ордод эрлийн ажил явуулж, 1:10 000 масштабтай геологийн зураг зохион, нөөцийн үнэлгээ өгсөн.

1960-1961 онд К.П.Атабекьянц нарын удирдлагаар Тарагтын гөлтгөнийн орд болон түүний дүүрэг дэх эрэл-зураглал, хайгуулын ажлыг гүйцэтгэхдээ Тарагтын районд 1:50000-ны масштабтай зураглалыг 100 км² талбайд хийж ашигт малтмал нь дээд цэрдийн Баянширээ формацийн эх газрын улаан өнгөтэй хурдаст агуулагддаг гэж үзжээ. Уг хурдас нь дөрөвдөгчийн сэвсгэр хурдсаар хучигдсан гэсэн дүгнэлтийг өгч, гөлтгөний нөөцийг А+В+С₁+С₂ зэргээр 1 073,5 мян.тн гэж үнэлсэн байна (ГМТ№1477).

1979-1982 онд Л.В.Заботкин нарын Дундговийн районд хийсэн 1:200000-ны масштабтай зураглалын ажлын үр дүнд Чамдмань овоо, Гут худаг, Ширээ уулын урд талын гөлтгөний илрэлүүдийг олж тэмдэглэсэн бөгөөд өмнө нь дээд цэрдийн настай гэж үзэж байсан Баянширээ формацыг палеогений настай хурдас болохыг дотор нь агуулагдсан амьтны үлдэгдэл болон бусад шинжилгээгээр тогтоон, литостратиграфийн өнөөгийн ангилалаар олигоцены настай Зодох формацад хамруулсан байна. (ГМТ№3676).

1980-1981 онд Төвийн геологийн экспедицээс Дундговь, Дорноговь, Өмнөговь аймгийн нутагт байрлах гөлтгөний орд, илрэлүүдэд эрэл-үнэлгээний ажлыг гүйцэтгэсэн бөгөөд Дэлгэрхангай сумын нутагт гөлтгөний ерөнхий эрлийн ажлыг явуулжээ.

2011-2014 ондуудад А.Амаржаргал, Б.Нямаа, нар Монгол улсын 1:200000-ны масштабын геологийн иж бүрдэл зураг зохиох “УГЗ-200 Өмнөд Монгол-VI” төслөөр тус хайгуулын талбай орших L-48-XXVII хавтгайд геологийн зураг зохиосон (ГМТ№7390).



Зураг 2. Дэлгэрхангай сумын нутагт орших “Урд тарагт” нэртэй XV-020375 тоот (3294.27га) хайгуулын тусгай зөвшөөрөлтэй талбай орчимд хийгдсэн 1:200000-ны судалгааны ажлын картограмм

ГЕОЛОГИЙН БҮЛЭГ

Судалгааны талбай нь Сүхбаатарын геоантиклиналь өргөгдлийн хойд хэсгийн структурт муж, Идэрмэгийн бүсэд багтана. Өмнөх геологийн судалгааны ажлаар Л.В.Заботкин нар (1982, 3676ф) тус талбайн баруун талаар олигоценей ангилагдаагүй хурдас, төв болон зүүн хэсгээр доод цэрдийн Тэвшийнговь формац, хойд болон урд хэсэгт бага талбайд дээд цэрдийн Долоонхудаг формацыг ялгасан байна (Зураг 3).

А.Амаржаргал нар (2014, 7390ф) уг талбайн баруун талаар бага талбайд олигоценей хурдас, хойно болон урд хэсгээр дээд цэрдийн Сайншанд формац, төв болон зүүн хэсгээр талбайн 70% орчмыг эзэлсэн доод цэрдийн Тэвшийнговь формацын хурдсыг зурагласан байна (Зураг 4).

Дэлгэрхангай орчмын гөлтгөний ордууд нь агуулагч чулуулагтайгаа нэгэн цаг үед үүсэж, давсны ханасан уусмалаас химийн замаар /эвапорит/ хуримтлагдсан буюу сингенетик төрлийн орд юм. Урд тарагт гөлтгөний орд нь энгийн геологийн тогтоцтой, дээд палеогены (олигоцен) настай хэвтээ байрлалтай, бор хүрэн, улаавтар өнгийн нягтарч хатуурсан шаврын үе дотроо гөлтгөний конкрец маягийн хуримтлалууд нь агуулагддаг.

Геологийн нэгжүүдийн нас, ангиллыг өмнөх геологийн судалгааны ажлуудаар ялгасны дагуу бид авч хуучин нутгийн стратиграфийн нэгж болох сери, свитүүдийг одоо мөрдөж байгаа “Монголын литостратиграфийн кодекс” (2007) дагуу групп, формац, мэмбэр гэсэн нэрээр өөрчилж, доор давхаргазүйг бичив.

СТРАТИГРАФИ

Тэвшийнговь формац /K₁tg/.

Нэрийн гарал, судалгааны түүх: Л.В.Заботкин нар 1979-1982 онуудад Дундговь аймгийн районд явуулсан 1:200 000 масштабтай геологийн зураглалын ажлаар Тэвшийн говь нүүрсний ордын нэрээр Тэвшийн говь формацад ялгаж, дотор нь 2 мэмбэрт хуваасан байдаг. Дараа нь Л.Мөнхтогоо, Б.Чулуун нар (1986,1987) Шинэ-Ус, Шивээ-Овоо, Адуунчулууны нүүрсний ордуудын урьдчилсан болон нарийвчилсан хайгуулын ажлын тайландаа Тэвшийнговь формацын хурдсыг ялгажээ.

Тархалт: Дундговь, Төв аймгийн нутагт Сайнцагаан сум Тэвшийн говийн нүүрсний уурхай, Баянжаргалан сум, Баян-Эрхэт уулын орчим, Дорнод аймгийн Адуунчулууны нүүрсний ордын орчимд тархалттай.

Илэрц: “Урд тарагт” нэртэй хайгуулын тусгай зөвшөөрөлтэй талбайд хурдас нь гадаргууд гарш илэрц муутай, намхавтар толгод үүсгэж илэрдэг. Сансрын зурагт (СПОТ-5 суваг-4,2,1) цайвраас тод ногоон, бор хүрэн, ногоон хүрэн өнгөтэй толборхог байдлаараа Сайншанд формацаас ялгагдана.

Стратиграфийн хил зааг: Доод цэрдийн Манлай, Баян-Эрхт формацуудыг үл нийцлэгээр хучиж, дээд цэрдийн хурдсаар өнцгийн үл нийцлэгээр хучигддаг. “Урд тарагт” нэртэй хайгуулын талбайд тус хурдас нь талбайн зүүн талаар зүүн хойш суналттайгаар, хэвтээ байрлалтайгаар доод цэрдийн Манлай формацын /K₁mn/ хурдсыг хучиж, дээд цэрдийн Сайншанд формац /K₂ss/-ын тунамал хурдсаар хучигдаж, олигоцены хурдас /E₃/-аар давхаргазүйн үл нийцлэгээр хучигдаж оршино.

Литологи: Л.Мөнхтогоо нар (1987) уг формацын хурдсыг дотор нь 5 мэмбэрт хуваасан. Ногоон-саарал, саарал алевролит, аргиллит, элсэнчулуу, нүүрслэг алевролит, нүүрс, шавар, конгломератаас тогтсон. “Урд тарагт” нэртэй талбайд улаавтар өнгийн шавар, шавранцар, алевролит, аргиллит, элсэн чулуу, нүүрслэг алевролит, нүүрс, конгломерат бүхий малосс маягийн хурдас зонхилно.

Зузаан: 900м зузаантай,

Палеонтологийн шинж: Алевролит агуулсан мэмбэрээс зөөлөн биетэн: *Limnocyrina wangshiensis* (Grab.), *Cordicula grabau* Martins., *Daurina sealaris* (Martins.), Үр тоосонцор:

Pinuspollenites consesa, *Cedripites* sp., *Pofocarpidites* sp., *Inaperturapollenites* sp., *Monoculcites* sp., *Lycopodiumsporites* sp., *Cyathidites minor.*, *Todisporites minor.*, *Foraminisporites dailyi.*, *Tricolpites.*, *Liliacidites* sp., *Classopolis* sp., *Araucariacites an gtralis*, *Ginisgocycadophytus* sp., *Pinaceas pollenite.*, зэргийн үлдэгдэл олддог.

Насны үндэслэл: Амьтан ургамлын үлдэгдэл, геологийн биетийн харьцаагаар нь доод цэрдэд хамааруулсан.

Сайншанд формац /K₂ss/.

Нэрийн гарал, судалгааны түүх: Анх уг хурдсыг Ч.Берки, Моррис нар Өөш формацын дунд хэсэгт хамруулж, доод цэрдийн нас өгч байсан. Дараа нь И.Е.Турищев (1954, Нижнемеловые отложения юго-восточной части МНР. ДАН СССР, новая серия, Т. 99, №3) дээд цэрдийн настай формацад ялгаж, 2 мэмбэрт ангилсан байдаг. Зарим судалгааны ажлуудад уг хурдсыг Шарил, Цагаанцав формацуудад хамруулж, заримд нь Баруунбаян формацын дүйцэл гэж янз бүрээр үздэг. Ихэнхдээ улаан, бага хэсэг нь саарал, ногоовтор өнгийн шавар, конгломерат, элстү хелее, элсэнцэр, гравелит, мергелээс тогтсон зузаалгийг Л.В.Заботкин нар (1982) Долоон худгийн нэрээр, стратиграфийн байрлалыг нь үндэслэн формацад ангилж Сайншанд формацтай адилтган сеноман ярустай дүйцүүлсэн байдаг. Харин А.Амаржаргал Б.Нямаа нар (2014) УГЗ-200 ӨМ-VI төслийн улсын геологийн зураглалын ажлаар дээд цэрдийн Сайншанд формацад нэгтгэж оруулсан байна.

Тархалт: Дорноговь, Өмнөговь аймгийн Цогт-Овоо сумын долоон худгийн орчимд, Өвөрхангай аймгуудын нутагт (L-47-XXIV; L-48-XIX; K-47-X; L-49-XXXII) хэмжээнд өргөн тархсан. Сайншанд формацын хурдас нь хайгуулын талбайн хэмжээд харьцангуй бага тархалттай ба талбайн хойд, урд хэсэгт гадаргууд гарш илэрц муутайгаар зураглагдсан байдаг.

Илэрц: Тус насны хурдас нь гадаргуугийн морфологи, сансрын зурагт тайлагдах байдлаараа бусад насны хурдас чулуулгаас ялгардаг. Сансрын зурагт бараан саарал, саарал өнгийн фототон үзүүлдэг.

Стратиграфийн хил зааг: Доод цэрдийн Манлай, Зүүнбаян формацыг үл нийцлэг хучиж, дээд цэрдийн Баянширээ формацаар нийцлэг хучигддаг. “Урд тарагт” хайгуулын талбайд доод цэрдийн Тэвшийнговь формацын хурдсыг хучиж, олигоцены ангилагдаагүй хурдсаар давхарга зүйн үл нийцлэгээр хучигддаг.

Литологи: Энэ формацыг И.Е.Турищев (1956) 2 мэмбэрт ангилсан байдаг. Улаан өнгийн конгломерат, конгло-брекчи, элсэн чулуу, алевролит, шавар, элсэрхэг шаврын зузаалгаас тогтоно.

Зузаан: 650м.

Палеонтологийн шинж, тулгуур зүсэлт: Уг формацын хурдсаас зөөлөн биетэн-*Campelonia yihsiensis*, *Oxynaia Sainshandica*, Острокод-*Cypridea rostrata*, *Cypridea prognata*, *Timiriasevia grata* болон динозаврын өндөг олддог.

Олигоцены ангилагдаагүй хурдас /E₃/.

Тархалт: Тус насны хурдас нь “Урд тарагт” нэртэй хайгуулын талбайн баруун талаар уртрагын дагуу сунаж тогтсон байрлалтайгаар 30 орчим хувийг эзлэж тархсан байдаг.

Стратиграфийн хил зааг: Энэ насны хурдас нь улаавтар болон ногоон өнгөтэй шавар, элс, гравелит, дайрга бүхий доод цэрдийн Тэвшийнговь формацын /K₁tg/, дээд цэрдийн Сайншанд формацын /K₂ss/ хурдсыг давхаргазүйн үл нийцлэгээр хучиж байрлана.

Литологи: Улаан өнгийн шаврын үеийн дээд хэсэгт гөлтгөнө агуулах бө гөлтгөнө нь шавар дотор жижиг талст болон үүр маягийн конкреци байдлаар, 1 мм-ээс 50 см, ховроор 80 см хүртэл хэмжээтэй тохиолдоно. Заримдаа гөлтгөний конкрецууд нь 1м хүртэл зузаантай тасралтгүй үргэлжилсэн давхарга үүсгэдэг. Энэ тохиолдолд шавар нь гөлтгөнө дотор 1-5см зузаан шаврын нимгэн үеүд байдлаар, нийт чулуулгийн 10-15% орчмыг эзлэн оршдог. Агуулагч улаан шавар нь химийн найрлагаараа усан гялтгануурт монтморилонит шавар болох нь лабораторын шинжилгээгээр тогтоогджээ. Гөлтгөнө агуулсан давхарга нь бараг хэвтээ байрлалтай /уналын өнцөг нь 0.5%, 0.25-8.0 м дунджаар 2.5-3.0 м зузаантай, ордын баруун хэсэгт гадаргууд ил гарч өгөршилд багагүй орсон, зүүн ба төвийн хэсэгтээ 10 м хүртэл зузаантай, шаврын үеэр хучигдсан байна.

Хайгуулын ажлын үед өрөмдсөн цооногийн зүсэлтийн (Цооног II-8/8) бичиглэлийг дээрээс доош бичглэвэл:

0,0-0,5 м- Бор шаргал өнгийн элсэнцэр бүхий хөрс.

0,5-2,0 м- Цайвар бор ногоон саарал өнгийн элсэрхэг шавар, шавранцар.

2,0-7,5 м- Гөлтгөний конкрец агуулсан улаавтар хүрэн өнгийн гөлтгөнжсөн шавар.

7,5-13,6 м- Сул барьцалдсан хайрга, хайрганцар 5-10 хувь агуулсан улаан хүрэн өнгийн шавар, шавранцар бүхий хурдсаас тогтоно.


Дээд плейстоцен-голоцен /dpQ₁₋₂/.

Тархалт: Дөрөвдөгчийн хурдас нь “Урд тарагт” талбайн нийт хэсэгт харьцангуй бага тархана.

Илэрц: Сансрын зурагт тайлагдах байдал сайн, цайвар саарал өнгийн зурваслаг фототоноор бусад насны хурдас чулуулгаас ялгарна.

Стратиграфийн хил зааг: Доод цэрдийн Тэвшийнговь, дээд цэрдийн Сайншанд формац болон олигоцений хурдсыг үл нийцлэгээр хучиж тогтоно.

Литологи: Дөрөвдөгчийн хурдас нь гарал үүслийн хувьд делюви-пролювийн гаралтай бөгөөд толгод жижиг уулсын бэл хормой тэдгээрийн хоорондох жижиг жалга сайруудаар тархдаг. Хурдас нь муу мөлгөржилттэй хагас өнцөглөсөн хайрга, хайрганцар, нарийн ширхэгтэй шаварлаг элс, элсэнцэр, хэмхдэслэг материал, ховроор конгломератаас суларсан хайрга, дайрга агуулсан байдаг.



Зураг 3. Дундговь аймгийн Дэлгэрхангай сумын нутагт орших "Урд тарагт" нэртэй XV-020375 тоот (3294.27га) хайгуулын тусгай зөвшөөрөлтэй талбай орчмын 1:200 000 масштабтай геологийн зураг (ГУФ № 3676)


Q_{iv} Современные отложения. Аллювиально-пролювиальные щебни, галечники, пески, супеси, суглинки, озерные глины, золотые пески.
 сугсыр, носоо, гравийтан, дресвяники, цооно, суглину, глина...

K_{1tg} Нерасчлененная. Сероцветные и зеленоцветные, редко красноцветные глины, алевроиты, пески, супеси, дресвяники, песчаники, гравелиты, аргиллиты, известняки, конгломераты, алевролиты, щебни, валунники, бурные угли, торфяники, битуминозные глины. В глинах и аргиллитах – конкреции сидеритов и бурых железняков.

K_{1tg2} Верхняя подсвита. Пестроцветные, сероцветные, красноцветные пески, гравий, супеси, алевроиты, дресвяники, щебни, конгломераты, глины, суглинки, валунники.

K_{1tg1} Нижняя подсвита. Сероцветные и зеленоцветные глины, аргиллиты, алевроиты, песчаники, пески, супеси, бурные угли, битуминозные глины, конгломераты, гравелиты, известняки, торфяники.

K_{1mn} Манлайская свита. Красноцветные, редко зеленоцветные валунники, щебни, валунные щебнистые суглинки, глины, супеси, песчаники, гравелиты, конгломераты, алевролиты, мергели.




Зураг 4. Дундговь аймгийн Дэлгэрхангай сумын нутагт орших “Урд тарагт” нэртэй XV-020375 тоот (3294.27га) хайгуулын тусгай зөвшөөрөлтэй талбай орчмын 1:200 000 масштабтай геологийн зураг (УГЗ-200 Өмнөд Монгол VI төсөл)

Эрвэл	Систем	Сери	Индекс	Илэрэгийн бүс	Индекс
Кайнозой	Деревяни	Голоцен	Q ₂	Голоцен. Аллюви-пролювийн (ар) хайрга, сайрга, хэснэгэр, шавраншар. Ховроор санхны гаралтай хэс (v)	
		Плейстоцен	Q ₁₋₂	Плейстоцен-голоцен. Пролувийн (р) хайрга, сайрга бүхий хэснэгэр, шавраншар, хэмхлэс, буд чулуу, нуур-пролювийн (лр) дайрга, сайрга аг	
	Плиоцен	Н ₂ -Q ₁	Плиоцен. Пролувийн гаралтай муу молгоржилтгүй буд, янз бүрийн хэмжээтэй хайрга, хэмхлэс, бага зэрэг боошог агуулсан хэс, хэснэгэр, шавраншар, сайрга		
		Н ₁ -Q ₁	Плиоцен-доод плейстоцений хуртас. Гравит, дресва, элэжин, хэснэгэр, шавраншар, мергелийн кокрентэй шавар, буд чулуу		
Мезозой	Цэрд	Дээд	K _{1bz}	Банггаг формац. Улаан ховроор саарал онгийн хэс, хэснэгэр, шавраншар, шавар, элэжин, гравелит, конгломерат, мергель, шохойжин.	
			K _{1ss}	Сайшанд формац. Улаан ховроор саарал, ногоон онгийн шавар, шавраншар, буд чулуу, конгломерат, элэжин, гравелит, мергель	
			K _{1tg}	Төвшийн говь формац. Ногоон ховроор улаан онгийн шавар, алеврит, хэс, хэснэгэр, элэжин, гравелит, аргиллит, шохойжин, конгломерат, хүрэн пүүрсний үс	
	Доод		K _{1mn}	Манлай формац. Улаан ховроор ногоон онгийн буд чулуу, дайрга, үйрэгтэй шавраншар, шавар, хэснэгэр, элэжин, гравелит, конгломерат, ал	
			K _{1mg}	Могойт формац. Конгломерат, элэжин, гравелит, шавар, шохойжин, вулканоген чулуулагийн хэмхлэхүүд. Ургамлын үлдвэрүүд: Surocites sp., Eguisetites sp., Elatocladus sp. Palaeopterostheria maleevi Novoj	
			J _{1sr}	Шарил формац. Конгломерат, буд чулуу, элэжин, гравелит, аргиллит, шавар, алевролит	
Юра	Дээд		Сүүбулсан бүртэм Риволит порфир		
Лопши			Гвадалупа онгийн интрузив бүртэм	Ш Фаз. Боржин сениит, шүдлэгдүү боржин, сениит (γξ)	
			P _{2zh}	Зэрт хулаг формац. Трахиданит, риоданит, шүдлэгдүү трахит болон трахиданит, трахиданит, риволитын туф, трахириолит, багальт, трахиандезит, элэжин, алевролит, аргиллит	

ПАЛЕОНТОЛОГИЙН СУДАЛГАА

“Урд тарагт” нэртэй XV-020375 тоот (3294.27га) хайгуулын тусгай зөвшөөрөлтэй талбай болон түүний ойр орчимд палеонтологийн хайгуул тандан судалгааг 34 ажиглалтын цэгт хийж, цэг бүрт тархсан хурдас чулуулгийн бичиглэлийг товч бичиж, олдвортой эсэхэд дүгнэлт өгч, фото зургаар бахимтжуулан координаттай нь доор бичиглэв.



- Ажиглалтын цэг, дугаар

Зураг 5. “Урд тарагт” нэртэй XV-020375 тоот (3294.27га) хайгуулын тусгай зөвшөөрөлтэй талбайн палеонтологийн хайгуул тандан судалгааны баримт материалын зураг.

АЦ 1: N 45° 0' 42.9" E 104° 32' 30.6"



Дээд цэрдийн хурдсаар зураглагдсан цэг. Энд үндсэн гарш илэрцгүй, гадаргууд янз бүрийн чулуулгийн хэмхдэс, хайрга бүхий сэвсгэр хурдас тархана.

АЦ 2: N 45° 1' 41.7" E 104° 31' 50.7"



Цэг орчимд доод цэрдийн Тэвийнговь формацын хурдас тархана. Энд үндсэн гарш илэрцгүй, гадаргууд янз бүрийн чулуулгийн хэмхдэс, хайрга бүхий сэвсгэр хурдас тархана. Палеонтологийн үлдэгдэлгүй.

АЦ 3: N 45° 1' 45.6" E 104° 31' 48.4"



Тэвийнговь формацын хурдас хэвээр үргэлжилнэ. Янз бүрийн чулуулгийн болон кварцын хайрга гадаргууд суларсан элсэрхэг хурдас, палеонтологийн үлдэгдэлгүй.

АЦ 4: N 45° 1' 39.5" E 104° 32' 57.9"



Цэг орчимд доод цэрдийн Тэвийнговь формац зураглагдсан байна. Энд хурдсын үндсэн гарш илэрцгүй, элэгдлийн гадаргад янз бүрийн хайргатай элсэнцэр, хайрганцар тохиолдоно.

АЦ 5: N 45° 2' 10.3" E 104° 32' 58.4"



Доод цэрдийн Тэвийнговь формацын элс, элсэнцэр тархана.Тэгш талархаг рельеф үүсгэнэ.

АЦ 6: N 45° 2' 10.8" E 104° 32' 55.6"



Доод цэрдийн Тэвийнговь формацын хурдсын хучсан дээд цэрдийн улаан шавар бүхий улаан эрэг байна. Энд үе үелэлгүй, палеонтологийн үлдэгдэлгүй элсэрхэг шавар шлэрнэ.

АЦ 7: N 45° 2' 11.4" E 104° 32' 52.4"



Доод цэрдийн хурдас хэвээр үргэлжилнэ.

АЦ 8: N 45° 2' 11.6" E 104° 32' 50.0"




Цэг орчимд сайр дагаж дөрөвдөгчийн хайрга, сайрга, элсэнцэрээс тогтох сэвсгэр хурдас тархана. Эрэг орчмоор арай өндөр рельеф үүсгэж улаан шаргал хурдас нь дээд цэрдийн Сайншианд формацын хурдас оршино. Палеонтологийн үлдэгдэлгүй.

АЦ 9: N 45° 2' 48.8" E 104° 29' 44.4"



Цэг орчимд олигоцений ангилагдаагүй хурдас зураглажээ. Хээрийн судалгаагаар энд янз бүрийн чулуулгийн муу мөлгөжрсөн хайрга, кварцын хэмхдэс бүхий элсэрхэг хурдас тархана.

АЦ 10: N 45° 2' 39.0" E 104° 29' 42.0"



Энэ цэг орчимд олигоцений гипсын үе агуулсан улаан, улаавтар өнгийн элсэрхэг, шаварлаг өнгийн хурдас тархана. Палеонтологийн ямар нэг үлдэгдэлгүй байв.

АЦ 11: N 45° 2' 38.6" E 104° 29' 37.0"



Олигоценый настай гипсын үе агуулсан улаан, улаавтар өнгийн элсэрхэг, шаварлаг өнгийн хурдас, жижиг толгодорхог рельеф үүсгэнэ. Үе үелэл ажиглагдахгүй, палеонтологийн үлдэгдэл илэрсэнгүй.

АЦ 12: N 45° 2' 33.5" E 104° 29' 26.8"



Гипс агуулсан улаан шаварлаг, элсэрхэг хурдсыг ухаж эргүүлж тавьсан байдалтай байна.Цэг нь талбайгаас гадагш баруун хойд талд байрлана.

АЦ 13: N 45° 2' 21.1" E 104° 29' 51.9"




Олигоценний ангилагдаагүй хурдас тархана. Гадаргууд үе үелэл, үндсэн шэрцгүй. Улаавтар, хүрэвтэр өнгийн шавар, элсэрхэг шавар, элснээс бүрдэнэ.

АЦ 14: N 45° 2' 26.5" E 104° 29' 19.2"



Хайгуулын цооног бүхий олигоцений улаан хурдас хэвээр үргэлжилнэ.

АЦ 15: N 45° 2' 9.2" E 104° 29' 25.3"




Талбайн гадна баруун хойд өнцөг дээр байрлана. Энэ хэсэгт олигоцений ангилагдаагүй хурдас зураглагдсан байна. Жижиг хайрга, сайрга, хэмхдэстэй хүрэвтэр өнгийн элс тархана.

АЦ 16: N 45° 2' 8.1" E 104° 29' 24.8"



Жалгын эрэг налуу хэсэгт улаан, хүрэвтэр улаан өнгийн гипс агуулсан шаварлаг, элсэрхэг хурдас илэрнэ. Үе үелэл болон палеонтологийн үлдэгдэл ажиглагдсангүй.

АЦ 17: N 45° 1' 41.0" E 104° 29' 55.8"



Цэг нь хайгуулын зөвшөөрөлтэй талбайн баруун хойно орших ба цэг орчимд гадаргуудаа вулканоген, тунамал, интрузив чулуулгийн 5-8 см хүртэл хэмжээтэй янз бүрийн хэмхдэс, муу мөлгөржсөн суларсан хайргатай улаан шаргал, шаргалдуу өнгийн сэвсгэр хурдас тархана.

АЦ 18: N 45° 1' 21.3" E 104° 29' 48.4"



Цэг нь мөн олигоцений хурдас дээр байрлана. Энд жижиг хайргануудтай элс, элсэрхэг хурдас тархана. Хайргууд нь дунд мөлгөржилттэй, голчлон цахиурлаг чулуулгийн хайргатай байв. Үндсэн илэрцгүй тул палеонтологийн үлдэгдэл байсангүй.

АЦ 19: N 45° 1' 18.0" E 104° 29' 47.1"




Олигоценний ангилагадаагүй хурдас, улаавтар элс, шаварлаг элс


АЦ 20: N 44° 59' 53.1" E 104° 30' 39.9"



*Янз бүрийн чулуулгийн хайргатай
Дөрөвдөгчийн сэвсгэр хурдас дороос
улаан шаварлаг хурдас цухуйна.*



АЦ 21: N 44° 59' 20.0" E 104° 30' 6.0"



Дээд цэрдийн Сайнишанд формацын хурдас, жижиг хайрга, сайргатай элсэрхэг хурдсаас тогтох бөгөөд үндсэн илэрцгүй тул палеонтологийн үлдэгдэлгүй.

АЦ 22: N 44° 59' 15.6" E 104° 30' 3.4"




Дээд цэрдийн Сайншанд формацын хурдас хэвээр үргэлжилнэ. Тэгш талархаг рельеф үүсгэнэ.

АЦ 23: N 44° 58' 57.4" E 104° 31' 7.3"



Доод цэрдийн Тэвийнговь формацын хурдас тархана. Янз бүрийн чулуулгийн 10 см хүртэлх хэмжээтэй өнцөглөсөн хайргатай, хэмхдэстэй элсэрхэг хурдас, палеонтологийн үлдэгдэлгүй.

АЦ 24: N 44° 59' 45.4" E 104° 30' 59.0"




Тэвшийнговь формацын хурдас хэвээр үргэлжилнэ.

АЦ 25: N 44° 59' 46.1" E 104° 30' 59.2"



Цэг нь дээд цэрдийн Сайншианд формацын хурдас дээр байрлана. Эндээс уг хурдсын тархалтын байдлыг, рельефийг харуулсан зураг авав. Жижиг хайргатай элсэрхэг хурдастай.

АЦ 26: N 44° 59' 38.7" E 104° 31' 21.4"



Тэвийнговь формацын хурдсаар зураглагдсан байна. Кварц голлосон хайрга, хэмхдэстэй хурдас дөрөвдөгчийнх бололтой.

АЦ 27: N 45° 0' 50.3" E 104° 31' 14.6"



Доод цэрдийн Тэвийнговь формацын суларсан, сайн мөлгөржсөн том жижиг хайргатай боровтор, саарал өнгийн элсэрхэг хурдас, палеонтологийн үлдэгдэлгүй.

АЦ 28: N 45° 0' 50.2" E 104° 31' 14.8"



Тэвийнговь формацын хурдсын тархалт, харагдах байдал

АЦ 29: N 45° 0' 50.6" E 104° 30' 48.7"




Тэвийнговь формацын хурдас, дундаас-сайн мөлгөржсөн, вулканоген, интрузив, тунамал чулуулгийн суларсан хайргуудтай конгломерат илэрнэ.

АЦ 30: N 45° 1' 6.9" E 104° 31' 9.2"



Тэвшийнговь формацын хурдас хэвээр үргэлжлэн тархана. Янз бүрийн найрлагатай хайргуудтай конгломерат. Үндсэн чулуулгийн гарш илэрцгүй, палеонтологийн үлдэгдэлгүй.

АЦ 31: N 45° 1' 36.4" E 104° 32' 6.6"




Доод цэрдийн Тэвийнговь формацын хурдас. Сайн мөлгөржсөн хайрга, конгломератын элэгдсэн гадаргуу. Палеонтологийн үлдэгдэлгүй.

АЦ 32: N 45° 1' 44.6" E 104° 31' 58.1"



Тэвийнговь формацийн конгломерат хэвээр үргэлжсэн тархана.

АЦ 33: N 45° 02' 59.4" E 104° 30' 19.2"



Олигоценний улаан, хүрэтэр өнгийн шаварлаг элс, элсэрхэг хурдас. Амьтан ургамлын ямар нэгэн үлдэгдэлгүй.

АЦ 34: N 45° 03' 10.1" E 104° 30' 06.6"



Олигоценний улаан, хүрэтэр өнгийн шаварлаг элс, элсэрхэг хурдас. Амьтан ургамлын ямар нэгэн үлдэгдэлгүй. Энэ шаварлаг хурдас дотроо гөлтгөнө агуулагддаг байна.



СТРАТИГРАФИ-ПАЛЕОНТОЛОГИЙН СУДАЛГААНЫ ТӨВ
RESEARCH CENTER for STRATIGRAPHY &
PALEONTOLOGY



ШУТИС-ийн төв байр, 8-р хороо,
Бага тойруу, Сүхбаатар дүүрэг
Улаанбаатар, Монгол улс
Шуудангийн хайрцаг 46/520

Палеонтологийн хайгуул, судалгааны ажлын дүгнэлт

Монгол улсын Иргэний хуулийн 343-358 дүгээр зүйлүүд, “Соёлын өвийг хамгаалах тухай” Монгол улсын хуулийн 2014 оны 5 сарын 15 ний өдрийн шинэчлэсэн найруулгын 38.1.2-д заасны дагуу 2018 оны 05-р сарын 06 наас 8- ны өдрүүдэд “Эхлэл ургац энерги” ХХК-ийн Дундговь аймгийн Дэлгэрхангай сумын нутагт орших “Урд тарагт” нэртэй XV-020375 тоот (3294.27га) хайгуулын тусгай зөвшөөрөлтэй талбайд ШУТИС-ийн Геологи Уул Уурхайн Сургуулийн Стратиграфи-Палеонтологийн судалгааны төвийн судлаач доктор Г.Сэрсмаа палеонтологийн хайгуул тандан судалгааны ажлыг хийж, эртний амьтан ургамлын олдвор, олдворт газар, илэрч болох магадлал буй эсэхэд үнэлэлт дүгнэлт хийв.

Тус хайгуулын талбайн төв болон зүүн хэсгээр доод цэрдийн Тэвшийнговь формац, хойно болон урд хэсгээр дээд цэрдийн Сайншанд формац, баруун талаар олигоценей ангилагдаагүй хурдас болон дөрөвдөгчийн хурдас тархана.

Өмнөх геологийн зураглалын ажлуудаар Өмнөд Монголд ялгагдсан доод цэрдийн Тэвшийнговь болон дээд цэрдийн Сайншанд формацуудын хурдсаас зөөлөн биетэн амьтан, динозаврын өндөг, эртний ургамлын үр тоосонцрыг илрүүлэн судалсан байдаг. Бидний хийсэн палеонтологийн хайгуул, тандан судалгаагаар тус тусгай зөвшөөрлийн талбайд тархсан дээрхи насны тунамал хурдсууд нь үндсэн гарш илэрцгүй, үе үелэл нь мэдэгдэхгүй жалга судагт илрээгүй бөгөөд гөлтгөнө агуулсан олигоценей хурдсаар болон дөрөвдөгчийн хурдсаар хучигдсан байв. Иймээс гадаргуугаас хийсэн ажиглалт, тандан судалгаагаар эртний амьтан, ургамлын ямар нэг чулуужсан үлдэгдэл илэрсэнгүй.


Цаашид эрэл хайгуул, олборлолт хийх зэрэг үйл ажиллагааны үеэр доод, дээд цэрдийн болон олигоценей хурдсаас организмын чулуужсан үлдвэр илэрсэн тохиолдолд ШУТИС, ГУУС-ийн Стратиграфи-Палеонтологийн төвд хандаж, Соёлын өвийг хамгаалах тухай хуулийн дагуу авран хамгаалах, малтлага хийлгэх ажил зохион байгуулахыг санал болгож байна. Ялангуяа динозаврын өндөг өмнөх судалгаануудаар ийм төвшний хурдсаас илэрсэн гэдэгт анхаарал хандуулж, болгоомжтой ажиллахыг зөвлөж байна.

Танай компани үйл ажиллагаандаа Соёлын өвийг хамгаалах тухай хууль захирамжийг хүндлэн сахиж, мэргэжлийн байгууллагатай хамтран ажиллаж байгаад талархаж байна.

ШУТИС, ГУУС-ийн Стратиграфи-Палеонтологийн судалгааны төв

Судлаач

Судлаач


Г. Сэрсмаа
Ж. Ундарьяа



Дундговь аймгийн Дэлгэрхангай сумын нутагт орших “Урд тарагт” нэртэй ашигт малтмалын хайгуулын XV-020375 тоот зөвшөөрөлтэй 3294.27 га талбайд хийсэн археологийн авран хамгаалах хайгуул судалгааны ажлын мэдээлэл

Монгол Улсын “Соёлын Өвийг хамгаалах тухай хууль”-ийн 5-р бүлгийн 27-р зүйлийн 8-т “Хот суурин, барилга байгууламж барих, шинээр зам тавих, усан цахилгаан станц байгуулах, газар тариалан эрхлэх, ашигт малтмалын хайгуул хийх, ашиглах зэрэг аж ахуйн үйл ажиллагаа явуулахад зориулан газар олгохоос өмнө палеонтологи, археологи, угсаатны мэргэжлийн эрдэм шинжилгээний байгууллагаар урьдчилан хайгуул судалгаа хийлгэж, дүгнэлт гаргуулах”, тус зүйлийн 9-т “Урьдчилсан хайгуул судалгаа хийлгэх, илэрсэн түүх, соёлын дурсгалыг авран хамгаалах ажилд шаардагдах зардлыг захиалагч хариуцна” хэмээн тус тус заасан байдаг. Тиймээс “Эхлэл Ургац Энержи” ХХК-ийн Дундговь аймгийн Дэлгэрхангай сумын нутагт байрлах “Урд тарагт” нэртэй ашигт малтмалын хайгуулын XV-020375 тоот тусгай зөвшөөрөл бүхий 3294.27 га талбайд ШУА-ийн Түүх, Археологийн хүрээлэнгийн судалгааны баг археологийн авран хамгаалах хайгуул судалгааг 2017 оны 11 дүгээр сарын 14, 15-ны өдөр хийж гүйцэтгэв. Хээрийн судалгааны багт тус хүрээлэнгийн эрдэм шинжилгээний ажилтан, доктор Н.Эрдэнэ-Очир, магистр Д.Одсүрэн нар оролцон ажилласан.


Энэхүү талбай Дундговь аймгийн Дэлгэрхангай сумын 2-р багийн нутагт, сумын төвөөс баруун өмнө зүгт шулуунаар 31.8 км зайд орших бөгөөд Тарагтын хөндий хэмээх өргөн хөндийн зүүн өмнөд хэсэгт хойноос урагш буюу уртрагийн дагууд 5.3 км, өргөрөгийн дагууд буюу баруунаас зүүн тийш 6.3 км хэмжээтэй зурвас газрыг хамран байрлажээ. Талбай нь бударгана, багалуур ургасан өргөрөгийн дагуу чиглэлтэй сунаж тогтсон хад асгагүй намхан гүвээ, талархаг газарт орших ба талбайн баруун хойд хэсэгт байх зүүн хойноос баруун урагш чиглэсэн хуурай сайрыг нутгийн олон Жирэмийн судаг хэмээн нэрийднэ.

Археологийн хайгуул судалгааг талбайн зүүн өмнөд хэсэг буюу XV-020375-03 цэгийн орчмоос эхлэн энгийн хайгуулын арга зүйг баримтлан хийж гүйцэтгэв.


Хайгуул судалгааны явцад уг талбайгаас эртний түүхийн дурсгал илэрсэнгүй. Энэ нь эртний нүүдэлчдийн зан үйл, тухайн зурвас газар нутгийн гадаргын байдал болон байрлалтай холбоотой хэмээн үзэж байна.

Хэдийгээр хайгуул судалгааны явцад “Урд тарагт” нэртэй ашигт малтмалын хайгуулын зөвшөөрөлтэй талбайгаас эртний түүхийн дурсгал илэрч мэдэгдээгэй боловч талбайн зүүн хойд хэсэг XV-020375-02 тоот цэгийн орчимд, талбайн гадна талд байх намхан дэнжийн өвөр биеэс шинэ чулуун зэвсгийн хэв шинжийг илтгэх залтас 2 ш илрүүлсэн. Мөн талбайн баруун хойд хэсэг Жирэмийн судаг, талбайн төв хэсэгт орших дэрстэй тойром нь Монгол орны говийн бүс нутгийн шинэ чулуун зэвсгийн олдворт газруудтай газарзүйн байрлалын хувьд ихээхэн төстэй бөгөөд чулуун зэвсэг хийх түүхий эд, цахиурын төрлийн чулуунууд, хас мэр сэр тааралдаж буйг тэмдэглэх хэрэгтэй.


Хайгуул судалгааны явцад “Урд тарагт” нэртэй, ашигт малтмалын хайгуулын XV-020375 тоот тусгай зөвшөөрөл бүхий 3294.27 га талбайгаас эртний түүхийн дурсгал илрээгүй боловч газрын гадарга дээр мэдэгдэх тэмдэггүй, шороонд булшлагдсан дурсгал, эд өлгийн зүйл, ялангуяа хүний нүдэнд тэр бүр өртдөггүй чулуун зэвсгийн олдворт газар байхыг үгүйсгэхгүй. Тиймээс аж ахуйн үйл ажиллагааны явцад анхаарал болгоомжтой байж, ямар нэг дурсгал, олдвор эд өлгийн зүйл илэрсэн тохиолдолд мэргэжлийн байгууллагад хандах хэрэгтэй юм.




“Урд тарагт” талбайн зүүн урд хэсэг, XV-020375-03-р цэгийн орчины байдал



“Урд тарагт” талбайн баруун урд хэсэг, XV-020375-04-р цэгийн орчины байдал



“Урд тарагт” талбайн баруун хойд хэсэг, XV-020375-01-р цэгийн орчины
байдал



“Урд тарагт” талбайн зүүн хойд хэсэг, XV-020375-02-р цэгийн орчины
байдал

